

ДӨЧИН ТҮМЭН БЭТЭ УЛС БОЛОН
ЖИДҮН УЛС
/үргэлжлэл/

М.Алтан-Оргил*

Саган Сэцэн «Эрдэнийн товч»-доо 1206 онд Чингис хааны байгуулсан Монгол улсын «Дөчин Түмэн Бэдэ Улс» гээд Чингис хааны язгуур дээдэс Бүртэ Чоныг ч «Бэдэ Улс»-д золгож ноён болсон гэдэг юм¹.

Тоба тайж «Их шар тууж»-д дээрхитэй бараг адил Бүртэ Чоныг Гоо Марал нэрт гэргийгээ аван «Бэдэ Улс»-д золгож ноён болсон гэжээ. «Бэдэ», «Бидэ»-г «Алтан хүрд мянган хэгээст»-д «Бита», «Пита», «Болор толь»-д «Вюнь» гэж бичжээ². Их түүхч(ин) Гомбожав «Гангийн урсгал»-даа онцгойлон «...Ба бүрэн нүүх Би та улс» гээд бас «Жэд» хэмээмү гэж тайлбарлажээ³. Их зохиолч, түүхч Инжинааш »Хөх судар»-таа Бэдэ-г төвд үсгийн авиаг дагаж «Бэтэ» гэж бичжээ.⁴ Дээр дурдсан зүйлүүдээс үзэхэд:

Нэгд, Аль эрт Чингис хааны язгуур дээдэс Бүртэ Чоно-ийн үеэс аваад өөрийн улс гүрнээ «Дөчин Түмэн Бэтэ Улс» буюу «Жэд улс» гэж нэрлэдэг байжээ. «Дөчин Түмэн Монгол Улс» хэмээн нэрийдэх нь яриангүй эрт дээр цагийн «Дөчин Түмэн Бэтэ Улс»-аас улиран хувьсан иржээ.

Хоёрт, Монголоор «Бэдэ», «Бидэ», «Бита», «Пита», «Вюнь», «Бэтэ» зэрэг олон янзын адил бус бичлэгээс үзэхэд тэр нь монгол үг биш, харь угсаа үндэстний нэрийдлийн авиачилсан тэмдэглэл билээ. Ийм учраас Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн эхлэх үүслийг сүвэгчлэхээс өмнө «Бэтэ», «Жэд» хэмээх нэрийдлийн ухагдахуун, энэ хоёр нэрийдлийн адил ба адил бус газар, тэдгээрийн дотоод бүрэлдэхүүн, түүхийн улиран хувьсалтын байдал зэргийг өгүүлэх нь чухал юм.

Зөвлөлт Холбоот Улсын үеийн монголч эрдэмтэн Шастина нь «Бэтэ» хэмээх нэрийдлийг эртний хятадын «бэйди» гэдэг нэрийдлийн авиачилсан тэмдэглэл⁵ болно гэж хамгийн түрүүнд зөв оновчтой дурдсан юм.

Инжинааш төвд үсгийн авиаг дагаж «Бэйди»-г «Бэтэ» гэж галиглан бичээд монгол үгийн «Бид» гэдэг утгатай юм гэж тайлбарласан нь буруу юм. Гэвч түүний бичлэгээс «Бэтэ» хэмээх нэрийдэх шууд хятадаас ирсэн биш, Төвдөөс дамжиж ирсэн гэдгийг мэдэж болно. Тийм биш бол Хятад бичиг, үсгэнд нэвтэрсэн Инжинааш түүнийг буруу ойлгох ёсгүй юм. Олны мэдээжээр Хятад үгийн «Бэй» гэдэг бол зүг чигийг заасан «умардахин» гэдэг утгатай бөгөөд тэр нь яриангүй монголын өндөрлөгийг зааж байсан, «Ди» нь Хүн- Түргүүд-Монголын нийтийн сүлд шүтээн, өөрөөр хэлбэл

*Өвөрмонголын түүхч эрдэмтэн.

онгон шүтээн⁶ Бөртэ Чоно болон галын тахилгыг үндэслэн нэрийдсэн бололтой. Эртний хятад сурвалж бичгүүдийн тэмдэглэлийг үндэслэн манай он тооллын өмнөх Хүн болон зүүн Ху-г бүр «Бэтэ» гэжээ. Хүний хойчисын эх овог, аймаг, Зүүн Ху-гийн хойчис Сяньби, Кидан, Хомохи, Шивы мөн тэрчлэн Түргүүд, Монгол болон Манжийн дээдэс Мэхэ-гч бүр Бэтэ гэдэг юм.⁷

Тэгвэл «Бэтэ» нь умардахины угсаа үндэстний нийтийн нэрийдэл мөн. Гомбожавын хэлсэн «Ба бүрэн нүүх Би та улс» гэсэн нь Бэтэ-г тайлбарласан байжээ.»Ба» нь язгуур монгол үг бөгөөд «Биднүүс» гэдэг утгатай юм. Нүүдэл улс гэж хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн нь Монголын өндөрлөгийн нүүдэлчин угсаа үндэстний байгуулсан улс гүрний бас нэгэн нийтийн нэрийдэл билээ. «Бэтэ улс» буюу «Нүүдэл улс»⁸-ын дотор Хүн Хаант Улс, Түргүүд Хаант Улс, Монгол Хаант Улс зэрэг бүгдээрээ багтах юм. Ийнхүү «Ба бүрэн нүүх Би та улс»-ыг «Биднүүсийн бүгд эсгий туургатан улс» гэж ойлгож болно. Асуудлын гол нь умардахины нүүдэлчин угсаа үндэстнүүдийн түүхийн адил бус үе шатанд байгуулагдсан эдгээр улс гүрнийг яагаад урьд хожид урт удаан хугацаанд бүр «Дөчин Түмэн Бэтэ Улс» гэж нэрлэдэг юм бэ? Үүний зөвхөн умар дахины нүүдэлчин үндэстэн Хүн, Түргүүд, Монголын түүхийн уламжлалаар тайлбарлаж болохгүй юм. Эдгээр улс гүрнийг байгуулалцсан угсаа үндэстний хооронд лав мах цусны холбоо байх ёстой. Орчин үед Монголын язгуур гарлын тухай хоёр өөр үзэл байна. Нэг нь, Монголыг Зүүн Ху-аас гаралтай гэдэг. Нөгөө нь, умардахины угсаа үндэстнүүдийн хамгийн сүүлчийн хаант улс сүүлийн дөрвөн Ойрадын холбоогоор суурь болгож байгуулагдсан Зүүн Гар Хаант Улсын өргөн олон малчин түмэн 1755-1758 оны хооронд Чин Улсын Тэнгэр тэтгэгч хаанд хэдэн зуун мянган хүн их хэмжээгээр хядагдан алагдсан байсан үед Францын Дежинайн зохиосон «Хүн, Түргүүд, Монгол болон өрнөдахины бусад татар хүмүүсийн нэвтэрхий түүх» гэдэг ном Парис хотод хэвлэгдсэн юм. Тус номд Монголыг Хүн-ээс гаралтай гэж хамгийн түрүүнд дурдан гаргажээ. Хоёр зуу гаруй жилийн хугацаанд энэхүү үзэл баримтлал нь Хаант Орос, дараа нь ЗХУ-ын зарим монголч эрдэмтдийн эсэргүүцэлтэй тулгарч байсан боловч дэлхий дээр зонхилох байр эзэлсээр иржээ. Хаант Орос дундад Азийн түргүүдийн олон угсаа үндэстний газар нутгийг булаан эзлээд тэд нарын нягтран холбоолохоос айж « Нармай Түргүүд»-ийг эсэргүүцэх тугийг өндөр мандуулж Хар Хүн-ий хаан Атила, Монголын Чингис Хаан, Төмөрлан хааны нэрийг дурдуулахгүй гэж их оролдож байсан юм. Одоо үед зарим цөөн бус хүмүүс Хүн болон Зүүн Ху-г адил бус хоёр өөр үндэстэн, Монгол нь Зүүн Ху-гаас гаралтай гэж үзэж байгаа⁹ бөгөөд энэ үзэл нь их түргэн дэлгэрч газар авч байна. Би энэ үзлийг үл зөвшөөрөх гэдгээ юуны өмнө илэрхийлсүгэй.

Аль эрт ясан дээр сийлэгдсэн хятад үсэг бичиг болон Чинь улс (МЭӨ 246-207)-аас өмнө зохиогдсон зарим хятад сурвалж бичгүүдээс эхлэн умардахины угсаа үндэстний түүхийг хэсэг бусаг тэмдэглэх болжээ. Умардахины угсаа үндэстний түүхийг системтэй найруулан бичсэн нь МЭӨ 104-91 оны үед Сыма Цяны найруулсан «Түүхийн тэмдэглэл» болох бөгөөд манай он тооллын өмнө эрт, Одоогийн гурван мянга орчим жилийн түүхийг багтаасан нэвтэрхий түүх юм. Тус номын зохиогч нь бусад угсаа үндэстний түүхийг бичихдээ, баримталсан байр суурь, үзэл бодол нь зарим талаараа одоогийн цөөн эрдэмтдээс хол илүү дэвшилттэй байжээ. Энэхүү «Түүхийн тэмдэглэл»-д тусгайлан «Хүн-ий намтар»-ийг найруулан оруулж хоёр мянга илүү жилийн хоорондох Хүн-ий түүхийн байдал, зан заншил, шашин шүтлэг, Хятад-Хүн-ий харьцаа, мөн тэрчлэн Хүн ий нэрийдлийн улиран хувиралт зэргийг бүр нэлээд нарийн тодорхой тэмдэглэжээ. Үүний хамт зохиогч бусдын амаар Хүн-ий зарим давуу талуудыг магтан сайшаасан юм. Хоёр мянга илүү жилийн өмнө Хятад үндэстний энэхүү агуу их түүхчийн найруулан зохиосон «Хүн-ий намтар» бол умардахины угсаа үндэстний язгуур гарлыг судлахад хамгийн эртний, хамгийн чухал сурвалж бичиг болох нь яриангүй юм.¹⁰ Тухайн үед Хүн өөрсдөө бичиг үсэгтэй байсан эсэхийг одоо тодорхой хэлж чадахгүй. Гэвч тэд дотор газрын хятад үндэстэнтэй харилцах үедээ хятад үсэг бичиг хэрэглэж байсан нь лавтай юм. Одоогийн мэдэж байгаагаар умардахины угсаа үндэстний дотроос Түргүүд Ү1 зууны үед үсэг, бичиг зохиож хэрэглэх болжээ. 7-8 дугаар зууны үеийн Түргүүд үсэг бичгээр сийлсэн зарим хөшөөний бичгүүд одоо хүртэл хадгалагдаж байна.¹¹ Дараа нь Кидан болон зөрчид нь Хятад бичиг үсгийг ашиглаж өөрсдийнхөө үсэг бичигтэй болов. МЭ 850-1250 оны хооронд Турфаны Уйгур хаант улсын үед Түргүүд үсэг бичгээ хэрэглэхээ больж Согдог үсгээр суурь болгож уйгур үсэг зохион хэрэглэх болжээ. Уйгур үсгээр бичигдсэн «Огус хааны тууль» одоо хүртэл хадгалагдаж байгаа, 1204 онд Чингис хаан Найман аймгийг харьяандаа оруулаад уйгур үсгийг суурь болгож уйгуржин Монгол бичиг зохиогоод 1240 онд дэлхийд алдартай «Монголын нууц товчоон»-оо бичээд уйгуржин монгол бичгээ монголчууд одоо болтол хэрэглэсээр иржээ.

Умардахины угсаа үндэстнүүдийн өөрийнхөө үсэг бичгээр өөрсдөө бичиж үлдээсэн хөшөөн бичгүүд, онцлон «Огус хааны тууль», «Монголын нууц товчоон» зэрэг бол Хүн, Түргүүд, Монголын хоорондох мах, цусны холбоо болон тэд нарын эл овог аймгийн нэрийдлийг судлахад хамгийн ховор нандин материал мөн бөгөөд бусад ямар ч бичиг, баримт материалуудыг тэдгээртэй зүйрлэхийн аргагүй юм. Учир нь тэдгээрийн зохиогдож тэмдэглэсэн түүхэн цаг үе нь хэтэрхий орой болохоор олонхи нь ардын уламжлал яриа билээ. Жишээлбэл: «Огус хааны тууль»-д Огус хаан болон түүний

суурийг залгамжилсан ахмад хөвүүн- Хүн хоёрын үеийг дурдаж байна. Хүн нь Хятадын уламжлал яриан дахь тэдний дээдэс Хуандитай нэгэн үед амьдарч байсан буюу түүнээс ч өмнөх хүн байсан юм. Тэгвэл Уйгур хаант улсын үед зохиогдсон «Огус хааны тууль» нь яриангүй уламжлал яриаг үндэслэсэн байх ёстой. «Монголын нууц товчоон»-д Чингис хааны хорин хоёр үеийн дээдсийг тэмдэглэсэн байна. Түүний дотор Бөртэ Чоноос Буданцар хүрэх арван хоёр үе нь үнэн хэрэгтээ мөн л ардын уламжлал яриаг үндэслэсэн мөртөө Бөртэ Чоно нь Хүн- Түргүүд-Монголын нийтийн сүлд шүтээн болсон юм. XVIII-XIX зууны үеийн зарим монгол сурвалж бичгүүдэд Монголын язгуур гарлыг хэсэг бусаг тэмдэглэсэн байгаа. Тэдгээр нь нэн хожим үеийн уламжлал яриа байснаас гадна шашны нөлөө ихтэй юм. Гэвч уламжлал яриа гэвэл үнэн худлыг ялгахгүйгээр бүгдийг үгүйсгэж болохгүй юм. Учир нь, дэлхийн эртний угсаа үндэстний язгуур гарлыг бүгд л уламжлал яриаг үндэслэн хэлдэг билээ. Рашид Ад дин «Судрын чуулган» номдоо Түргүүд-Монголын эл овог ястан бүр язгуур гарал, өвөг дээдсээ нарийн тодорхой цээжилж хойч үеийн үр ач нартаа үе улиран хэлж сургах уламжлалтай гэж Түргүүд-Монголын ардын уламжлал яриаг их хүндэтгэн үзэж өөрийн номоо бичихэд гол баримт болгожээ¹². Үнэндээ Түргүүд-Монголын ардын аман зохиолд, ялангуяа баатарлаг туульсад тэд нарын язгуур гарлын тухай эх баримтуудыг бага бус үлдээж хадгалжээ. Үүнийг Рашид Ад дин аль эрт олж мэдээд «Огус хааны тууль»-ийг өөрийнхөө номд найруулан оруулаад бас зарим зүйлүүдийг тухайн үеийн уламжлал яриаг үндэслэн нөхсөн байжээ. Гэтэл Рашид Ад дин бол лалын шашинтан болохоор зарим зүйлийг шашны хандлагаас засчээ. «Хүн-ий түүх» мэтийн хятад сурвалж бичгүүдийг «Огус хааны тууль»-ийн уг эх бичиг болон «Монголын нууц товчоон» зэрэг холбогдол бүхий сурвалж бичгүүдтэй харьцуулан судалбал, Рашид-ын зассан зүйлүүдийг олж мэдэхээс гадна Хүн-Түргүүд-Монголын язгуур дээдэс нь нэг гэснийг амархан мэдэж болох юм.

Сыма Цяны «Хүн-ий түүх»-д МЭӨ 221 оноос МЭ 220 он хүртэлх үеийн Хүн-ийг Хүннү буюу Ху гэж нэрлээд Хүн-ийг дотор нь оршин нутагшсан зүг чиглэлээр нь Хүн, Зүүн Ху гэж ялгажээ. Хятадууд эрт дээр үеэс нутаг орныг уулын зүүн, баруун гэж нэрлэдэг. Уулын зүүн, баруунд нутагласан хятадуудыг хоёр үндэстэн гэж хэлж болохгүйтэй адил Хүн болон Зүүн Ху-г хоёр үндэстэн гэж хэлж болохгүй юм. Тэднийг заавал хоёр өөр үндэстэн гэж үзье гэвэл тухайн үеийн үг, хэл зэрэг адил бус талаар нотлох хэрэгтэй. Харин хол хожмын үеийн Түргүүд Монгол Зүрчид үг хэлний зарим зөрөөтэй талыг үндэслэн эн тэр гэж тааж болохгүй юм. Нөгөө талаар сүүлийн үеийн Түргүүд, Монгол, Зүрчидийн үг хэл хоорондоо ямар их зөрөө байлаа ч бүгд Алтай хэлэнд багтах юм. Одоо солонгос, япон хэлийг ч бас Алтай хэлэнд багтаана гэж үздэг болжээ¹³. Тэгвэл хожим үеийн

эдгээр олон угсаа үндэстнүүдийн дээдэс нь эрт дээр цаг үед бүр Алтай төрлийн язгуур хэл-өвөг Хүн хэлтэй байсан байх ёстой. Тийм бишээ гэж эдгээр угсаа үндэстний хэл харилцан нөлөөлөн нэгэн төрлийн Хэл болсон гэвэл, нүүдэлчин үндэстний түүхийн хөгжлийн онцлог болон хожим үеийн түүхт хэрэг явдлуудтай нийцэхгүй юм. Түүхийн урт удаан хөгжлийн явцад Алтай төрлийн язгуур хэлнээс Түргүүд, Монгол, Зүрчид хэлүүд салж гарсан юм. Хожим үеийн Түргүүд, Монгол, Зүрчид төрлийн хэлний хоорондох зөрөөг үндэслэж хоёр гурван мянган жилийн өмнөх Хүн болон Зүүн Ху-г адил бус хэлтэй хоёр үндэстнээр үзэх нь хэрэг дээрээ түүхийг тонгоруулсан явдал болно. Үүнээс гадна зарим түүхч Хүннү-г монгол арьстан биш цагаан арьстан гэж хэлэх нь түүхийн үнэн байдалтай огт нийцэхгүй юм.

Сыма Цян «Түүхийн тэмдэглэл»-дээ Хүннү болон Зүүн Ху-г нэг угсаа үндэстний адил бус бүрэлдэхүүн гэж хэлсний хамт хятадын уламжлал яриан дахь Хуа Ся (хятад үндэстний язгуур дээдэс, Хуандигийн үеийн Хунь Юй, Яо-шүний үеийн Шянь-юнь, МЭӨ 2197 1818 оны Ся улсын үеийн Сүн-юй, МЭӨ 1765-1145 оны Шан улсын үеийн Хуй-фан, МЭӨ 11122-249 оны Жоу улсын үеийн Сүн-июй зэрэг нь мөн нэг угсаа үндэстний түүхийн адил бус үе шатын адил бус нэрийдэл болгож «Хүн-ий түүх»-д оруулан бичжээ.

Миний үзэхээр Хятадын балар эртний уламжлал ярианд хэлдэг үер усны гамшигийг ялж, тариаланг хөгжүүлж Хятадын түүхэнд хамгийн түрүүний, анхны улс гүрнийг байгуулсан Ся-юй хааны нэр цол ч дээр дурдсан Сянь-Юнь зэрэг нэрийдлийн адил бус авиачилсан тэмдэглэл байжээ. Учир нь Ся улсын хаан Юй бол Рун үндэстэн, Хятадын дээдэс Хуандигийн хойчис биш юм. Рун болон Ди нь нэг үндэстний адил бус нэрийдэл юм. Үүгээр үл барам эртний Хятад сурвалж бичигт тэмдэглэсэн Ся-юй хааны хойчис Хүннү-гийн дээдэс Сүн-юй гэдэг нэр ч Сянь юнь зэрэг нэрийдлийн адил бус авиачилсан тэмдэглэл мөн. Одоогийн хятад хүмүүс өөрсдийгөө «Хуа ся үндэстэн гэж хэлдэг нь үнэн хэрэг дээрээ Хүн-Түргүүд-Монголын дээдэс дотор газарт хамгийн түрүүнд байгуулсан улсын нэрээр хятадууд өөрийн үндэстний нэрийдэл болгосон явдал мөн. Ийнхүү тус өгүүлэлд Хятадын Ганьсү мужийн Дүнхуан агуйгаас олдсон эртний Согдог үсгийн бичлэгийг үндэслэж Хүннү зэрэг нэрийдлийн эхний үсгийг Хүн гэж сэргэсэн билээ. Согдог үсгээр «Вон» гэж бичиж «Хүн» гэж уншдаг гэнэ. Эртний үед Хүн-ийг Перс-д «Күн», Энэтхэгт «Хүнэ» гэж бичдэг юм. Хүн нь наран гэдэг утгатай язгуур Түргүүд-Монгол үг юм.

«Огус хааны тууль»-д Огус хааныг Хүн-ээр туг хийж түүний хаан сууринг залгамжилсан ахмад хөвгүүнээ Хүн гэж нэрлэсэн гэдэг. Тэгвэл Хүн хэмээх угсаа үндэстний нэрийдэх нь улсын туг сүлд болон хааны нэр наран гэдэг үгнээс иржээ гэдэг нь яриангүй.¹⁴ Энэ нь ТҮ-ҮІ зууны үед Энэтхэгийн хойт хэсэгт цөмрөн орсон цагаан Хүн-

ийг санскрит үсгээр «Наран угсаатан» гэж бичсэнтэй чав хэмээн нийцдэг. Хятадын Чинь Хань /МЭӨ 246-МЭ 220 он/ улсын үед хэлдэг Хүннү, Ху бүр Хүн хэмээх угсаа үндэстний адил бус авиачилсан тэмдэглэл буюу дөхөмчилсэн нэрийдэл болно. Үүнээс гадна «Хүн»-ий түүх»-д тэмдэглэсэн Чинь, Хань улсаас өмнөх дээр дурдсан Хүн-юй, Сянь-юй, Хүй-фан зэрэг нэрийдэл нь доорхи зүйлийн нийтлэг тал байна. Нэгд, эдгээр нэрийдлүүдийг бүр хятад үгийн хоёр үсгээр авиачлан тэмдэглэжээ. Хүй-Фан-гийн «Фан» нь газар орны засаг төрийг заадаг. Хоёрт. Эдгээр монгол үсгээр тэмдэглэвэл бүр «Х», «С»-ээр эхэлдэг. Монголын зарим нутгийн аялгуунд «С»-ийг «Х»-ээр авиалдаг юм. Жишээлбэл: Барга, Буриад аялгуунд «Сайн» гэхийг «Хайн» гэдэг. Ийм учраас Хунь, Сянь, Сүн, Хүй, Хун, Ху зэрэг нь бүр Хүн хэмээх нэг үгийн адил бус авиачилсан тэмдэглэл гэж үзэж болно. Гуравд. Эдгээр нэрийдлийн хоёр дахь үсгийг одоогийн монгол үсгээр юй, эсвэл юйн гэж бичиж болно. Эрт дээр үед хятад үсгийн «Юй» гэдгийн ну» гэж уншдаг.¹⁵ Ийнхүү Хятадын хэлдэг «Хүннү», энэтхэгчүүдийн хэлдэг «Хүна», Персчүүдийн хэлдэг «Хүн» зэрэг нь үнэндээ «Хүн» гэдэг үгийн адил бус авиачилсан тэмдэглэл болно. «Хүн» нь наран гэдэг утгатай «Юй» эсвэл «Ну» Дотор газар Ся улсыг байгуулсан «юй» хааны нэрээс иржээ. Хүннү зэрэг нэрийдлийг наран хаан буюу наран хааны улс угсаатан гэж ойлгож болно. Юй хаан МЭӨ 2197 онд Ся улсыг байгуулаад улсын нийслэлээ Наран хот гэж нэрлээд хожим нийслэлээ шилжүүлээд Наран- Ди гэжээ. Энэхүү Ди болох дээр өгүүлсэн Ди нь бүр умардахины угсаа, үндэстнийг заадаг бөгөөд эхнийх нь тэд нарын од үрвэлгээний засал чимэглэлийг үндэслэсэн бол дараагийн нь Хүн-Түргүүд-Монголын онгон шүтээн болон галын тахилгыг үндэслэн нэрийджээ. Хүн-ий хамаг дээд ноёрхогчийг Шань юй гэдэг нь «Хань» юй» байснаасаа улиран хувьсаж «Хану, Ханну» болжээ. «Хань юй» гэж эхлэхдээ Ся улсыг байгуулсан юй хаан, хятадуудын хэлдэг Ся-хоу-г хэлжээ. Эдгээрийг үндэслэж умардахины угсаа үндэстний зарим овог аймгийн нэрийдлийг сэргээж болно. Жишээлбэл: Хүн-ий овог аймаг дотор Юй вэнь гэдэг аймаг одоогийн Өвөр Монголын зүүн хойтод байгаа Нуун мөрний урсгал дагуу нутагт Сяньби Шилбэтэй холилдон малжиж байжээ. Энэхүү аймгийн нэрийдлийг «Нугуун, Нагуун, Нуун» гэж гол мөрний нэрээр сэргээж болно. Нугуун нь өнцөг, булан гэдэг утгатай язгуур монгол үг билээ. МЭ 317-420 оны үеэс эхэлж одоогийн Өвөр Монголын Хянган аймаг, Шилийн гол аймаг орчимд «Ди-доу-юй» гэдэг аймаг малжиж байжээ. Хятад сурвалж бичгүүдэд Хумахи-г Хүн-ийг нуун аймгаас гаралтай гэдэг бөгөөд Түргүүдээр Дад бэй гэдэг юм¹⁶, дээр дурдсан Ди-доу-юй болон Дадбэй нь нэг нэрийн адил бус авиачилсан тэмдэглэл болно. Ди доу юй гэдэг нь хожмийн монголын татар аймгийг хэлж байна. Татар нь «Тар» гэдэг үгийн үндэс Дээр «дан» дагаврыг залгаж «Тадан» болжээ. Тэр нь нуун лугаа утга ойролцоо хөвөө, ирмэг гэсэн

утгатай юм. Урьд хожид Кидан болон Түргүүдтэй харъяанд байсан Хумахи, Ши болон монголын татар аймаг нь бүр Хүн-ий нуун аймгийн хойчис болно. Мөн Ди доу хааны нэр ч татар гэдэг үгтэй холбоотой байж мэднэ. МЭ 900-аад оны үед Хянган нурууны баруунд Хөлөн, Бойр нууруудын зүүнд Юй-Чюэ гэдэг аймаг малжиж байжээ. Юй-Чюэ нь язгуур монголын Нэгүс аймгийн авиачилсан тэмдэглэл билээ. Ингээд МЭӨ 246-МЭ 220 оны үеийн Хүннү, Ху мөн түүнээс хол эрт үеийн Ся-юй, Сүн-юй, Хунь-ЮЙ, Сянь-юй, Хүй фан зэрэг нэрийдэл нь Хүн-ий адил бус түүхэн шат үеийн адил бус авиачилсан тэмдэглэл юм. Мэ YII зуунаас эхлээд өнөөг хүртэл хятадын түүхчид чингэж үзэж байсан юм.

Сыма Цяны «Хүн-ий түүх» болон эртний бусад хятад сурвалж бичгүүдэд Хүн-ийг зарим үед «Чюань рун» гэж нэрийддэг. Үүнийг Хүн-ий адил бус авиачилсан тэмдэглэл гэж үзэж болохгүй юм. Харин түүнийг Хүн-Түргүүд Монголын нийтийн сүлд шүтээн Бөртэ-Чонын утгачилсан орчуулга нэрийдэл гэж үзвэл зүйтэй юм. Эртний ясан дээр сийлсэн хятад бичигт Чюань-ийг одоогийнхоос арай өөрөөр бичдэг байсан бөгөөд тэр нь хээрийн нохойн «Чоно» гэдэг утга санааг илтгэж байлаа. Рун нь цэрэг буюу цэргийн зохион байгуулалтыг зааж хэлсэн юм. «Огус хааны тууль»-д Огус хаан Хүн ээр туг болгон ахмад хүүгээ Хүн гэж нэрлээд Бөртэ Чонод дайралдааны уриа болгож шар гэрлээр Бөртэ Чоно харагдахад дайн байлдаан хийж ялалт олдог гэжээ. «Суй улс 7581-618/-ын түүх»-ийн «Түргүүдийн намтар» Түргүүдийн дайралдааны тугийн оройд Чоноийн толгойтой гэж тэмдэглэсэн байдаг. «Монголын нууц товчоон»-д эхлэнгүүт: «Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ Чоно ажуу. Гэргий инү Хуа Марал ажээ» гэдэг бөгөөд Алун Гуа эх эргүй бөгөөтлөө Боржигон овогтны дээдэс Бутанцарыг төрсөн учир шалтгааныг тайлбарлахдаа: «Шөнөд бүр цэгээн шар хүмүүн гэрийн өрх дутуугийн гэгээгээр орж хэвлий мину илж гэгээн ину хэвлий дор мину шингэх бөлгөө.Гарарун наран саран хилээр шар нохой мэт шилбэлзэж гарах бөлгөө»¹⁷ гэдэг юм. Дээр дурдсан хээрийн нохой, цагаан чоно, Бөртэ Чоно, Цэгээн шар хүмүүн, Шар нохой зэрэг нь Хүн-Түргүүд-Монголын нийтийн сүлд шүтээн чоно-ыг хэлж байгаа ажээ. Монголчууд одоо болтлоо чоно-ыг тэнгэрийн нохой гэдэг бөгөөд хоол идэж байгаа үед Чоно гэж хэлбэл аягаа хөмөрч нэрийг нь цээрлэдэг юм.

Эртний хятад сурвалж бичгүүдэд умардахины угсаа үндэстний нэрийдлийг хэдийгээр нэгдэлгүй элдэв янзаар авиачлан, утгачилан орчуулж тэмдэглэдэг байсан боловч үсгийн хажууд ихэнхидээ нохой гэдэг утгатай дүрс үсэг нэмдэг байжээ. Энэ нь Хүн-Түргүүд Монголыг нохой гэж доромжлон хараасан хэрэг биш, харин тэдний нийтийн сүлд шүтээн Бөртэ Чоноор бусад угсаа үндэстнээс ялган тодолсон явдал юм. Эрт дээр үеэс эхлэн Бөртэ Чоноор сүлд шүтээн болгож галын тахилга хийдэг нь Хүн-Түргүүд-Монголчуудын сэцэн

мэргэн боловсон соёлтой байсныг харуулж байна. Манжийн Тэнгэр тэтгэгч хааныг дуурайн хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэдэг умардахины угсаа үндэстний нэрийдлийн хажууд дагалддаг нохой утгатай үсгийг өөрчлөхөөр аашлах буюу Японы хийсэн «Бөртэ Чоно» киног ийм тийм гэж хэлэх нь өөрийн угсаа үндэстнийхээ түүхийг мэдэхгүй, мэдлэггүй гэснээ харуулж байгаа явдал юм. Одоо зарим эрдэмтэд Монгол болон Түргүүд бүгдээрээ Бөртэ Чоно-г сүлд шүтээн болгосон нь зөвхөн түүхэн уламжлал төдий хэрэг, сонирхолтой зүйл биш, мах цусны холбоогүй гэж хэлж байгаа. Гэтэл Хүн-Түргүүд-Монголчууд түүхэнд өөрийн сүлд шүтээнээ дур тааваараа өөрчлөхийг хэлэх байтугай, өөрийн овог, аймаг, ястан, өвөг дээдсийн нэрээ халж өөрчлөхийг хамгийн муу хэрэг, шившиг, ичгүүртэй хэрэг гэж үздэг заншилтай юм.

Хятад хүний нэрийддэг Хүннү, Чюань Рун зэрэг нэрийдлийг сүүлийн үед болоод Хүннү, Сюань Рунгийн хойч үрдэс Түргүүд Монголчууд ч сайн ойлгохгүй болж элдвээр таамагладаг болсон юм. Тэдгээр таамаглалууд нь ардын уламжлал яриагаар дамжин итгэж болшгүй үлгэр домог болж хувираад, тэр нь Түргүүд-Монголын зарим овог аймгийг дамжин дахин хятад сурвалж бичгүүд, гадаадын жуулчдын тэмдэглэлүүдэд тэмдэглэгдсэнээс гадна ХҮИ-ХИХ зууны зарим монгол сурвалж бичигт ч бичигджээ¹⁸. Жишээлбэл: ХИИ зууны үед Чингис хаан, нэвтэрхий хэхүүдэгт улс, өвчүүндээ нүхт улс, Чөтгөр зүст улс, Нохой толгойт улс, Охин царайт улс, Ганц нүдэт улс зэрэг элдэв сонин улс гүрнийг өөртөө нэгтгэсэн гэдэг¹⁹. Үүнийг зарим хүмүүс одоо болтол учрыг нь олоогүй бөгөөд гэнэт авч үзэхэд үнэхээр итгэх аргагүй ажээ. Гэвч нарийвчлан бодож судлан үзвээс эдгээр нь бүр хятадын нэрийдсэн нэрийдэл буюу Түргүүд-Монголын өөрсдийнх нь уламжлал ярианаас иржээ. Олны мэдээжээр ХИИ зууны үед Чингис хааны нэгтгэсэн нь голдуу монголын өндөрлөг болон дундад Азийн Түргүүд-Монголын олон овог аймаг өөрөөр хэлбэл угийн Бэтэ улс буюу эсгий туургатан улсын олон овог аймаг болно. Тэгвэл Нэвтэрхий хэхүүдэгт улс буюу өвчүүндээ нүхт улс нь - Хүн; Чөтгөр зүст улс нь - Хүй фан; Нохой толгойт улс нь -Чюань Рун; Охин царайтай улс нь -Зүрчид; Ганц нүдэт улс нь-Бутанцараас гадна Дува сохорын хойчисын захиргаанд байсан аймгуудын нэрийдлийн хятад үсгийн бичлэгийг яг тэр чигээр нь ойлгож монгол орчуулга болгож бичсэн байжээ. Их зохиолч Инжинаашийн Бэтэ хэмээх нэрийдлийн үүссэн цаг үе болон Төвдөд уламжлан хэрэглэгдсэн цаг үеийг товч өгүүлбэр. Ойрын жилүүдийн эртний булшны олдвор, хуучид судлалын шинжилгээний материалууд болон эртний хятад сурвалж бичиг, тэмдэглэлээс үзвэл: Хүн-ий олон аймгууд анх монголын өндөрлөгөөр төв болгож урагшаа одоогийн Ганьсу, Нинься, Шэньси, Шаньси, Хэбэй мужийн нутгуудад хятад үндэстэнтэй хөрш зэрэгцэн амьдарч байжээ. «Хүн-ий түүх»-д тэмдэглэснийг үзвэл

тухайн үед Хүн-ий тахилгын орон нь одоогийн Шэнь Си мужийн Си ань хотоос баруун хойш дэмий холгүй Гань-Чюаньшань уулын доор байжээ²⁰. Ийм байдалтай үед хятадууд Хүн-ий олон аймгуудыг Бэй Ди гэж нэрлэхгүй юм. Балар эртний уламжлал яриагаар Хятадын Дээдэс Хуандигаар толгойлуулсан овог аймгууд одоогийн Хятадын баруун хойт орноос зүүн өмнө зүгт Хатан голын дунд, доод урсгал дагуу нутагт - нүүдэллэн иржээ. Бодоход Хүн-ий зарим овог угсаа ч мөн тэр цаг үед монголын өндөрлөгөөс урагш нүүдэллэн очсон байжээ. МЭӨ 1122-МЭӨ 246 оны үед, хятад сурвалж бичгүүдэд Хүн ий аймаг угсааг Улаан Ди гэх мэт дөрвөн өнгөөр ялган хэлдэг байжээ. Энэ нь Хүн-ийг цагаан Хүн, хар Хүн, татарыг цагаан татар, хар татар гэж ялгагдагтай адил юм. Умардахины угсаа үндэстний энэхүү уламжлал нэрийдлийн арга нь эрт дээр үеийн бөө удган нараас дөрвөн өнгө: Хөх, улаан, цагаан, хараар дорно, өмнө, өрнө, умар дөрвөн зүйлийг нэрлэдэгтэй холбоотой юм. Хожим монголчууд таван өнгө, дөрвөн харь гэж Хөх монголыг төв болгож улаан хятад, шар сартуул, цагаан солонгос, хар тангад гэж хэлдэг болжээ. МЭӨ 475-221 оны үед дотор газар хятадууд Чи, Чу, Янь, Хань Чинь, Жао, Вэй долоон улс хүчирхэгжин мандаад нүүдэлчин Хүн-ий олон овог аймгуудыг Муна /мони/ уулын ард түрэн гаргаж бэлчээр нутгийг нь булаан эзлээд Хүн- лугаа хил нийлдэг газруудаар тус тусдаа урт цагаан хэрэм байгуулж сахин хамгаалдаг болсон юм. МЭӨ 221 ОНД Цинь-Шихуан дотор газрыг нэгтгээд Хүн-ий олон овог аймгийг их Дийлж хойш хөөгөөд урт цагаан хэрмийг дахин нэг алхам бэхлэн байгуулжээ. Ингээд дотор газар хятад буюу хятадчилсан үндэстэнтэй хамт оршин амьдарч байсан Хүн-ий овог аймгууд урт цагаан хэрмээс хойш нутаглах болсноос Бэтэ /Бэйди/ гэж нэрлэгдэх болсон юм. МЭ 618-907 оны хооронд хятадын Тан улсын үед хятад, Төвдийн харьцаа сайжрахыг дагалдан хятадын Бэтэ болон Ху хэмээх нэрийдэл Төвдөд уламжлагдан хэрэглэгдэх болсон бололтой. Одоо цагийн Хятадын түүхчид энэ тухай өгүүлэх нь эртний хятад эрдэмтэдтэй адилгүй. Дотор газарт малжиж байсан Хүн-ий овог аймгуудыг гадагш хөөн гаргаад урт цагаан хэрмийг байгуулж тэд нарыг Бэтэ гэж нэрлэсэн гэж хэлдэггүй. Харин умардахины Хүн-ий довтлол дайралтаас хамгаалан сэргийлэх зорилгоор урт цагаан хэрмийг байгуулсан гэж байна.

«Огус хааны тууль»-д хэлснийг үндэслэбэл Түргүүд хэмээх нэрийдэл нь Огус хааны доорхи «Үлүг түрүг» гэдэг их түшмэлийн нэрээс ирсэн бөгөөд тэр нь Огус хаан болон түүний хаан сууринг залгамжилсан Хүн-лүгээ нэгэн цаг үеийн хүн байжээ. «Үлүг» нь их гэдэг утгатай Түргүүд үг мөн, Түргүүд нь «Тэргүүн» буюу «Түрүүн» хэмээх үгийн доор олон тооны дагавар «Д»-г залгаж аймгийн нэрээ болгожээ. Үлүг түрүг нь их түрүү хэмээх утгатай бөгөөд тэр нь цагаан сахалтай, буурал толгойтой, арга ухаан, бодол олонтой төв голч, сүүн цагаан сэтгэлтэй хүн байжээ.²¹ Огус хаан Үлүг Түрүг-ийн

зөвлөснөөр цэрэг иргэдээ зүүн, баруун гар болгон хуваагаад өөрийн хүүхэд ач нартаа хуваарилан өгсөн гэнэ. Рашидын »Судрын чуулган« д тэмдэглэсэн Огус хаан болон түүний хүү Хүн-ий захиргаанд байсан Түргүүд хорин дөрвөн аймаг нь үнэн хэрэгтээ Сыма Цяны «Хүн-ий түүх»-д тэмдэглэсэн Хүннү-гийн хорин дөрвөн түмнийг хэлж байдаг юм. Үүнийг тэд нарын амьдарч байсан цаг үе, газар нутаг, цэрэг засгийн зохион байгуулалт дотоод бүрэлдэхүүн, түүхт үйл явдал зэрэг олон талаар баталж болно.

Рашидын «Судрын чуулган»-д Түргүүд-Монголын нийтийн дээдсийн нэрийг Абулжа хаан, Төв Яхуй гэж хоёр үеийг тодорхой тэмдэглэсэн бөгөөд тэд нар нь XIV зуунаас өмнө 4-5 мянган жилийн эрт дээр үед байжээ. Огус хааны эцэг Хар хаан бол Төв Яхуйн хүү юм. Огус хааны хүү Хүн нь Абулжа хааны тавдугаар үеийн үрдэс юм.²² Үүгээр үзвэл XIII зууны эцэс, XIV зууны эхэн үед Рашид «Судрын чуулган»-аа бичихэд түүнд «Огус хааны тууль»-аас гадна бол Түргүүд-Монголын ямар нэгэн ховор нандин сурвалж бичиг байсан буюу эсвэл зарим зүйлүүдийг тухайн үеийн монголын Болд чинсан мэтийн алдарт түүхч, туульч, үлгэрч нарын хэлснийг үндэслэн нөхсөн байж магад. Тийм биш бол эмч мэргэжлийн перс хүн Рашид Ад дин нь Түргүүд-Монголын эрт дээр үеийн түүхийн байдлыг тодорхой мэдэх бололцоогүй юм. Хүн-ий дээдэс Абулжа хаан, Төв Яхуй, Хар хаан, Огус хаан зэрэг дөрвөн үеийн хүмүүс нь Хятадын уламжлал яриан дахь дээдэс гэдэг Хуандигаас нэн эрт дээр үеийн хүмүүс юм. Үүгээр үл барам Монголын өндөрлөгөөс шинээр олдож байгаа Улаан Хадын соёлын үлдэц зэрэг нь түүхт цаг үеэрээ дотор газрын Хатан голын дунд, доод урсгал дагуу хятад соёлын үлдцээс наад зах нь мянга гаруй жилээр эртнийх юм. Энэ нь Монголын өндөрлөгөөс хүчирхэгжин мандсан Хүн-Түргүүд-Монгол ядахдаа тав зургаан мянган жилийн боловсон соёлтой гэснийг гэрчилж байна. Монголын өндөрлөгөөс үүссэн боловсон соёл нь дотор газрын соёлд нөлөөлж түүний хөгжилд түлхэц болсон юм. «Огус хааны тууль»-д Огус хаан Зүрчид, Тангад, Ром, Орос, Сам, Энэтхэг, Мажар зэрэг олон улс, угсаатныг байлдан дагуулсан гэж буй. Эдгээрийн заримыг тайлбарлъя. Ром гэж эртний Итали улсын Ром хотоор нийслэл болгосон Ромын Хаант улсыг хэлсэн биш, одоогийн Туркийн бага азийн газар нутгийг хэлсэн юм. Сам нь одоогийн Сири улс юм. Монгол судлалын нэрт эрдэмтэн Пеллио нь Мажарыг Египет гэж үзэж байсан юм. Гэвч 1240 онд бичигдсэн «Монголын нууц товчоон»-д одоогийн Унгарыг Мажар гэж хэлдэг юм. Персийн Жувэйни-гийн зохиосон «Дэлхийг байлдан дагуулагчдын түүх»-д мажарыг Хэрэйр гэдэг ажээ. Рашидын «Түүхийн чуулган»-д Огус хаан цэрэг, иргэд, газар нутаг булаацалдан олон жилийн дайн байлдаан хийж эцэг Хар хаанаа хороож Түргүүд Хаант улсаа байгуулаад авга нараасаа хагацаж нэг үндэстэн нь хоёр хэсэг болсон гэдэг юм.²³ Гэвч Рашид номондоо Түргүүд-Монголын

олон овог аймгийг нийдэм Түргүүд гэж нэрлээд тэд нарын газар нутгийг Түргүстан, Уйгуртан болон Монголстан гэж хоёр хэсэг болгож хуваасан байдаг юм. Түргүстан, Уйгурстан голдуу Хивчак, Орос, Еркис, Баскид, Талас, Сирэм, Ибэр Шибэр, Балад Ханхас зэрэг газар орныг багтаагаад, Монголстанд голдуу: Эрчис, Хар хурам, Алтай, Орход, Далан Балжус, Бурхан Халдун, Хөлөн, Буйр, Хэргэд, Ойн, Эргүнэ, Халайр, Сэлэнгэ, Баргужин, Төхөм, Халалжин, Алууд болон урт цагаан хэрэм хавийн Өнхөг зэрэг газар орныг багтаажээ. Үүний хамт Түргүд нь цэргийн хүч, дайн байлдаанаар эрх сүрээ Хятад, Энэтхэг, Кашмир, Иран, Ром, Сам, Египет хүртэл өргөтгөжээ²⁵ гэсэн байлаа. Эдгээр нь эртний хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Хүн хаант улсын газар нутгийн хүрээ хэмжээ болон түүний гадагш байлдан дагуулсан дайн байлдааны байдалтай их төлөв нийцдэг ажээ. Сы ма-Цяны «Хүн-ий түүх»-д тэмдэглэсэнийг үзвэл МЭӨ 209 онд Хүн хаант улсын Түмэн хааны хүү МЭ 94 онд хаан эцгээ хороож хаан сууринг залгамжлаад одоогийн Өвөр Монголын зүүн хэсэгт, нутаглаж байсан Зүүн Ху-г дийлж, МЭӨ 200 онд МЭ 94 онд хаан Хятадын Хань улстай дайлалдаж одоогийн Шаньси мужийн Датун хотын зүүн дэх Бай дэн шань ууланд Гао-ди хаан Лю-банг ихээр ялж урт цагаан хэрмээр зах хязгаар болгохоор зөвшилдөж Хань улсаас жил бүр Хүн хаант улсад тогтоосон ёсоор алба барих гэрээ байгуулжээ. Гэвч хоёр улсын ноёрхогчид гэрээгээ зөрчдөг байснаар барахгүй Хань улсаас явуулсан хагацуулах бодлогын үр дүнд МЭ 48 онд Хүн хаант улс, өмнөт, умард хоёр хэсэг болж задраад өмнө Хүн нь Хань улсад бууж өгөөд умард Хүн-ий төв нь говийн арын Бурхан Халдун уул орчимд шилжив. Хань улсын эрх баригчдаас Хүн хаант улсын сүр хүчийг бүрмөсөн устгахын тулд говийн ард удаа дараа их цэрэг явуулж умард Хүн хаант улсын ард иргэдийг хядаж мал сүргийг дээрэмддэг байжээ. Ийм байдал доор МЭ 91 онд умард Хүн хаант улсын гол хүч нь Бурхан Халдун уулын орчмоос дахин дундад азийн Сири голын дээд урсгал дагуул нутагт шилжжээ.²⁶ Гадаадын зарим сурвалж бичгүүдийн тэмдэглэснийг үзвэл Умард Хүн хаант улс нь Сирэмийн газарт хоёр зуу гаруй жил өнгөрөөд дахин хүчирхэгжин мандаж Хар, цагаан Хүн гэж хоёр хэсэг болжээ. Цагаан Хүн нь ТҮ-ҮИ зууны үед Иран, Сам, Египет, Энэтхэгийн хойт хэсэг зэрэг өргөн уудам газар нутгийг эрхшээлдээ оруулж XIII зуунд Чингис хаан барууныг дайлах хүртэл цагаан Хүн-ий хойчисийн ноёрхолд байжээ. Хар Хүн нь IV зуунд Оросын Өмнөт талаар цөмрөн орж V дугаар зуунд Мажарын газар нутгийг эзэлж зүүн Европын хаант улсыг байгуулсан юм. Монголын нууц товчоон»-д тэмдэглэсэн Монголын аймгийн нэр хэрэйд, Жувейни-н хэлдэг Мажарын Хэрэйр зэрэг нь бүр эрт дээр үеийн Огус хааны эцгийн нэр- Хар хаанаас ирсэн билээ. Учир нь, Хэрэйд болон хэрэйдийн үгийн язгуур нь бүр «Хар» юм. Бодоход, МЭ 91 онд умард

Хүн-ий гол хүчин баруун тийш нүүдэллэхэд угтаа Хар хааны нэрээр нэрийдсэн Хэрэйд нь Монголын тал нутагт үлдэж хоцроод хожим монгол болоод Хэрэйр нь баруун тийш нүүдэллээд эцэстээ Мажарын нутагт нутагшжээ. Зарим монголч эрдэмтдээс одоогийн Унгар улсын хүн амын хэсгийг Түргүүд-Монголтой дээдэс нэгтэй гэж хэлдэг нь зөв юм. Умард Хүн хаант улс баруун тийш нүүдэллээд дахин хүчирхэгжин мандаж байсан үед Хань улсад бууж өгсөн өмнөт Хүн-ий олон овог аймаг дотор газар удаа дараа нүүдэллэн ороод аажмаар Хятадын дунд ууссан юм. Түргүүд- Монголын баатарлаг туульс болон уламжлал ярианд яригддаг Хүн болон Түргүүдийн газар нутгийн хүрээ хэвчээ нь дотоод гадаадын олон сурвалж бичгүүдийн тэмдэглэлүүдтэй их төлөв адил юм.

Рашидын «Судрын чуулган»-д тэмдэглэсэнээр Огус хаан зургаан хүүтэй байсан бөгөөд хөвгүүд тус бүр нь дөрвөн хүүтэй байжээ. Огус хаан Үлүг Түрүгийн зөвлөгөөгөөр зургаан хөвгүүд болон хорин дөрвөн ач нараа зүүн, баруун хоёр гар, хорин дөрвөн аймаг болгон хуваахдаа ахмад хүү Хүн-наран, Хоёрдугаар хүү Ай Саран, гуравдугаар хүү юлдус-Одон болон тэр гурвын тус бүрийн дөрвөн хөвгүүний захиргаан доорхи арван хоёр аймгийг баруун гар болгожээ. Дөрөвдүгээр хүү Хөхөө-тэнгэр, тавдугаар хүү Таг-Уул, зургадугаар хүү Тэнгис болон тэр гурван тус бүрийн дөрвөн хөвгүүдийн захиргаан доорхи арван хоёр аймгийг зүүн гар болгожээ.

Эд нэгэн аймгийг зүүн гар болгожээ. Хятадын Чинь /МЭӨ 246-207 / улсаас өмнө Хятад үсэг бичгээр зохиогдсон « Уул тэнгис хэмээх судар» болон « Их атар хэмээх судар» зэрэг номууд чөтгөр сахиусаар голлож газар зүй болон зан заншлыг тэмдэглэжээ. Зарим хүмүүс түүнийг бөө мөргөлийн зохиол гэдэг юм. Эдгээр номын хамгийн сонирхолтой тэмдэглэл гэвэл: Хаан Сүн-ийг зүүн зүгийн тэнгэрлэг хаан, Наран, Сараны эцэг, хүн төрөлхтөний язгуур дээдэс гэдэг юм Тэгвэл Огус хааныг Хаан Сүн гэж хятадаар тэмдэглэсэн биш үү? Өнгөрсөнд цөөн бус эрдэмтэд Хятадын зүг чиглэлээр Зүүн зүгийн тэнгэрлэг хаан Сүн-ийг далайн эрэг хавийн газар нутгийн хаан гэж үздэг байжээ. Хэрэв Хүн-ий Түргүүд- Монголын байршлын зүг чиглэлээр авч үзвэл тэр нь яг хятадуудын хэлдэг умардахины буюу монголын өндөрлөг юм аа. Тэгвэл дээр дурдсан номууд нь дотор газар үлдэж хоцорсон Хүн- Түргүүд- Монголын дээдэс нь хятад үсэг бичгээр зохион үлдээсэн ууган зохиолууд байж мэднэ.

Сыма Цяны «Хүн-ий түүх»-д хэдийгээр Огус хаан болон түүний хүүхэд ач нарын нэрийг нэг нэгээр дурдаагүй боловч Хүннү-г мөн зүүн баруун хоёр гар хорин дөрвөн түмэн болгож хуваасан гэдэг юм. Аймаг болон Түмэн нь нэг утгаар хэрэглэгддэг гэж дээр өгүүлсэн билээ. Үнэн хэрэг дээрээ дээрхи хоёр зохиолч өөрсдийн номондоо нэг л зүйлийг л хэлсэн байлаа. Жич, «Огус хааны тууль» болон Рашидын «Судрын чуулган»-д Огус хааны ургийн хойчисын захиргаан доторхи хорин дөрвөн аймгийн дээдсийн нэрийг нэг нэгээр

дурдсанаас гадна бас Огус хааны төрсөн ах, дүү нарын болон үеэлэд ах дүү нарын захиргаан доорхи Уйгур, Хангин Хивчиг, Харлох, Харч, Агч, Эри зэрэг овог аймгийн гарал үүслийг нарийн тодорхой тайлбарлажээ. Огус хаан аян дайнд явж Ижил мөрнийг гатлах үед түүний ордны хэрэг явдлыг хамаарагч Үлүг Ордон Бэх гэдэг цолтой Сэцэн мэргэн хүн онгоц хийж мөрнийг гаталсан учир түүнийг Хивчаг гэж нэрлэсэн гэнэ.²⁸ Хивчаг гэж дотор нь хөндий модыг хэлдэг юм. Огус хаан мөсөн давааг давахад унаж явсан хамгийн хайртай морио алдчихсан гэнэ. Энэ үед түүний доорхи бүдүүн чийрэг биетэй, бэрхшээл зовлонгоос айдаггүй дайн байлдаанд гарамгай эр уулан дотор 9 хоног эрж алдсан морийг нь олж ирэх үед бүх бие нь мөс цас болсон учраас түүнийг Харлог гэж нэрлээд тус нутагт Бэх өргөмжилсөн гэнэ. Огус хаан төмөр хаалгаар гарах үед түүний цэргээс нэгэн уран, мэргэжилтэй хүн хаалга нээж гавъяа байгуулсан учир түүгээр төмөр хаалгыг сахиулж харч гэж нэрлэсэн гэдэг. Огус хаан Зүрчиний хааныг алаад их хэмжээний олзлогсад болон эд хогшлыг тээвэрлэх унаа хөсөг хүрэлцэхгүй болсонд нэгэн уран мэргэжилтэй цэрэг Бармаглуг Жосон билиг гэдэг хүн өндөр аралт тэрэг хийж тээвэрлэсэн бөгөөд аралт тэрэг нь зам явахад «Хангар, хангар» гэж дуу чимээ гардаг учраас тэрэг баригчдыг Хангин гэж нэрлэжээ. Хангиныг хятадаар гао-чэ гэдэг бөгөөд тэр нь өндөр аралтай тэрэг гэсэн утгатай юм. Анхаарууштай нь: «Огус хааны туульчид Байгал нуурын орчин тойрон болон Енисей мөрний дээд урсгал дагуу газруудаас хүчирхэгжиж мандсан олон аймгийн дотроос Түргүүд, Хангины гарал үүслийг тайлбарласан мөртлөө Хиргисийг ер дурдсангүй байжээ. Үүний хамт Огус хааныг Уйгурын дээдэс гэж хэлдэг. Рашидын «Судрын чуулган»-д тайлбарлахдаа Уйгур нь Огус хааны ах дүү нарын захиргаан доорхи аймаг байсан бөгөөд хавсрагч гэдэг утгатай. Учир нь Огус хаан өөрийн эцэг Хар хаан болон хэдэн авга нартайгаа муудалцаад дайн байлдаан хийх явцад уйгур хавсарч дэмжицгээжээ. Энэ нь зүйтэй байх аа. «Огус хааны тууль»-д гардаг Олон овог аймгуудын нэрс нь эртний хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэнээс гадна түүхийн үнэн байдалтай нийцэж байдаг. Гэвч хятад сурвалж бичгүүдэд тэдгээр овог аймгуудын гарал үүслийг тодорхой оновчтой тайлбарлаагүй мөртлөө олонхидоо нэг л овог аймгийн нэрийг адил бус олон янзаар авиачлан тэмдэглээд дараа нь энэ олон авиачлан тэмдэглэсэн нэрсээ адил бус аймаг ястан болгон үзэж хүмүүсийн толгойг эргүүлж төөрөгдүүлж иржээ. Хүн хэмээх нэрийдлийг хятадаар адил бус олон янзаар авиачилан утгачилан орчуулдаг гэж дээр өгүүлсэнтэй адилаар Түргүүдийг Тин-Лин гэж хоёр янзаар, Дин ли, Зэлэ, Теэ-лэ, Тун-лө, Ту-чюэ, Хиргисийг -Гэ Кунь, Жянь-Кунь, Чи-гу, Жие-гу, Жие-хэсы, Шя-хэсы, Жи-лижис гэж тус тусад нь адил бус түүхийн шат үеийн адил бус тэмдэглэл байдаг. Дээр өгүүлсэн байдлаас авч үзвэл онцгойлон «Огус хааны тууль» болон Рашидын «Судрын чуулган» мөн Сымя Цяны «Түүхийн

тэмдэглэл» зэрэг сурвалж бичгүүд болон баатарлаг туульсууд нь умардахины эртний угсаа үндэстний язгуур гарлыг судлахад үнэхээрийн туйлын элбэг баялаг, үнэ цэнэтэй эх материалуудыг хангаж өгсөн боловч зохиолчдын зарим зүйлүүд нь урд, хойноо зөрчилтэй газрууд байгаа юм. Тэдгээрээс зарим зүйлүүдийг эрх биш тайлбарлах чухалтай.

Сыма Цянаас Хүн-юй, Сянь-юнь, Сүн-юй, Хүй, Хүннү, Ху зэргийг нэг угсаа үндэстний нэрийдлийн адил бус авиачилсан тэмдэглэлээр үзэж тэдгээрийг бүр «Түүхийн тэмдэглэл»-ийн «Хүн-ий түүх»-д оруулж бичсэн боловч Хүннү-г Ся-хэушы-гийн хойчис гэж бичжээ. Энэ нь тус номын «Таван хааны намтар»-т Хүн-юй-г, өөрөөр хэлбэл Хүннү-т хятадын дээдэс Хуанди-н үед байсан гэж үзсэнтэй зөрчилтэй юм.³⁰ Юу гэвэл Хуанди бол Ся-хэуши-гээс хол эрт дээр үеийн хүн бөгөөд Хуанди-гийн үед байсан Хүннү-г буцаад Ся хэушыгийн хойчис гэдэг нь түүхийн цаг үеийг тонгоруулсан явдал болно. Гэвч Хүннү болон Ся-хэушигийн хойчисыг хоорондоо мах цусны холбоотой гэсэн нь үнэн байх ёстой. Тэгвэл Ся /МЭӨ 2205 1766 улс Шан улсад мөхөөгдөх үед Ся-зегийн хүү нь Сүн-юй дээдийн нутаг Монголын өндөрлөгтөө зугатан ирж нэг угсаа төрлийн Хүн-лүгээ хамт амьдрах нь зүй ёсны хэрэг юм. Рашид, Огус хаан болон түүний гурван үеийн дээдсийн 14 дүгээр зуунаас дөрөв, таван мянган жилийн эртний хүмүүс гэж бичээд нэг үндэстэн байснаа хоёр хэсэг болж салсан учир шалтгааныг хэлэхдээ Огус хаан Исламын шашныг шүтсэн, түүний эцэг Хар хаан болон гурван авга нь уг хэвээр Онгон шүтээнээ шүтсэнээс болсон гэжээ. Энэ нь бас л түүхийн цаг үеийг тонгоруулсан байлаа. Учир нь, Ислам бол YII зууны эхэн үед үүссэн, түүнээс өмнө гурван мянган жилийн эрт үед амьдарч байсан Огус хаан нь Исламын шашныг шүтэх ёсон алга. Олны мэдээжээр Рашид өөрөө лалын шашинтан байжээ. « Судрын чуулган»- даа Хүн-Түргүүд-Монголын түүхийн алдарт хаадын бөө мөргөлийн шүтлэгтэй байсныг өөрчлөн хэлэх буюу нуун далдалж Огус хааныг лалын шашныг үүдэн бүтээгчийн хойчис бөгөөд үнэнч шудрага муслин гэж бичсэн нь бурхан шашны хутагт хувилгаандаас Чингис хааныг Манзушира бурханы хувилгаан гэж түүний язгуур дээдсийг Энэтхэг, Төвдийн хаадаас гаралтай гэж хэлж бичиж байсантай адилаар бүр тухайн үедээ тус тусын шашнаа дэлгэрүүлэхийн тулд Монголын хаад, ноёдын дэмжлэгийг олох гэсэн явдал байлаа. Шинээр олдсон «Огус хааны тууль»-ийн уг эхний бичлэгийг үндэслэвэл: Огус хаан бол ёстой бөөгийн шашныг шүтдэг байжээ. Тэр хөвгүүдээ Наран, Саран, Одон, Тэнгэр, Уул, Тэнгис гэж нэрлээд нараар туг хийж, Бөртэ Чоноор дайралдааны уриа болгон, Үлүг-Түргүү-гийн санаачлагаар цэрэг иргэдээ зүүн, баруун хоёр гар болгон хуваажээ. Их чуулган, баяр найр хийх үед хааны ордны зүүн, баруун талд хоёр мод босгож орой дээр нь алтан тахиа, мөнгөн тахиа

дүүжилж доор нь цагаан ямаа, хар ямаа уядаг гэжээ. Эдгээр нь яриангүй бөө мөргөлийн ёслол мөн болой.

Рашид номондоо Огус хааны нэгэн хөвгүүний нэр нь Хүн наран, мөн Түргүүд хэмээх нэрийдэл нь эрт дээр үеэс байсан гэсэн боловч Огус хаан нь Хүн-Наранаар туг хийж Бөртэ Чоноор дайралдааны уриа болгосон, хожмийн үе болоод Огус хааны хойчисийн захиргааны олон овог аймгийг Огус гэж нэрийдсэн, мөн түүний хаан сууринг залгамжилсан ахмад хөвгүүний нэрээр Хүн Наран гэж нэрийдсэн байсныг ер дурдаагүй юм. Тэгсэн мөртлөө Рашидын номонд, мөн Жувейни-гийн зохиосон «Дэлхийг байлдан дагуулагчдын түүх» зэрэг перс үсэг дээр зохиогдсон түүхийн зохиолуудад Огус хааны шууд хойчис, түүний ах дүү нар болон авга нарын хойчисын захиргаан доорхи овог аймгуудыг, өөрөөр хэлбэл Хүн-Түргүүд-Монголын бүх овог аймгуудыг бүгдийг Түргүүд гэж нэрийддэг ажээ. Эдгээр нь үнэн хэрэг дээрээ Хүн-ээс хойших үеийн түргүүд хэмээх нэрээр эртний Хүн хэмээх нэрийг орлуулан, бас Монголоос эрт үеийн түргүүд хэмээх нэрээр хожмын монгол хэмээх нэрийг орлуулсан явдал болжээ. Үүнээс болоод зарим эрдэмтэд одоо болтол перс үсгийн түүхийн зохиолуудад Түргүүд хэмээх нэрийдэл түгээмэл хэрэглэгддэг учир шалтгааныг шинжлэн судлахгүй дураар таах, үгүйсгэх, эсвэл Түргүүд хэмээх нэрийдэл нь нүүдэлчдийн нийтийн нэрийдэл байсан гэж ойлгодог. Гэтэл перс үсэг дээр зохиогдсон түүхийн номд Араб болон Европ тивийн нүүдэлчин үндэстэнг түргүүд гэж ер хэлдэггүй юм. Дээр өгүүлсэнтэй адил «Огус хааны тууль»-д Түргүүд хэмээх нэрийдэл нь Огус хаан ба түүний хаан сууринг залгамжилсан ахмад хүү Хүн-ий үеийн их түшмэл Өлөг Түрүг гэдэг хүний зэрэг цолоос иржээ. Энэ нь Рашидын «Судрын чуулган»-д Түргүүд хэмээх нэр эрт дээр үеэс байсан гэдэгтэй яв цав нийцэж байна. МЭӨ 221-127 оны үеэс хятад сурвалж бичгүүдэд Түргүүд гэдгийг Дин лин гэж авиачлан тэмдэглэсэн байжээ. Тэр үеэс хойш Түргүүд хүчирхэгжин мандах хүртэлх зургаан зуу орчим жилийн хугацаанд Түргүүд болон Хангины газар нутаг нь Байгал нуурын орчин тойронд байсан бөгөөд Хангин нь зарим үед өөрсдийгөө мөн Түргүүд гэж нэрийддэг байжээ.

Үүнээс үзэхэд нэлээд эртнээс Түргүүдийн дотор олон овог, аймаг багтаж байжээ. МЭ 317-420 оны үед Түргүүдийн олон овог аймаг хүчирхэгжин мандаж Солонгосын хойгоос дундад азийн Сири мөрөн, Амуй мөрөн хүртлэх өргөн уудам газар нутгийг Түргүүд Монголын олон овог аймгуудыг нэгтгэн хүчирхэг их Түргүүд хаант улсыг байгуулагдсан байжээ. МЭ 583 онд Түргүүд хаант улс нь мөн л хятадын хагацуулах төрийн бодлогод өртөн зүүн, баруун хоёр хэсэг болон задарчээ. Баруун Түргүүд хаант Улс нь Чүй мөрний урсгал дагуу Мин булаг, өөрөөр хэлбэл, Хүн-ий гол хүрч, баруун тийш нүүдэллэсэний дараа хаан ордон байгуулсан газраар төв болгосон

юм. Энэ цаг үеийн талаар XIII зууныг хүртэл дэмий удаагүй, газар орон нь өмнө тийшээ Персээс холгүй байжээ. Ийм учраас XIII зууны үеийн Персийн түүхч Жувейни болон Рашид нар нь Чүй голын Үүрдийн төвөөр ойлгож Хүн-ий дараах Түргүүд хэмээх нэрийдлээр эртний Хүн гэдэг нэрийг орлуулж нэгэн угсаа төрийн хүн болон түргүүд хоёрыг нарийн тодорхой ялгаагүй байх аа. Үүний зэрэгцээгээр тэд өөрсдийн номдоо Түргүүд, Татар, Монгол гурван нэрийдлийг нэг утгаар хутгалдуулан хэрэглэжээ. Энэ нь мөн л Түргүүд-Монголыг нэг угсаа төрлөөр үзсэн явдал мөн. Төвд сурвалж бичгүүдэд эртний хор/ хоор/ хэмээх нэрийдлээр хожим үеийн Түргүүд болон монгол хоёр нэрийг орлуулан, монголыг төвдөөс ялгах үедээ Согбо гэж хэлдэг юм.³¹ Хор /хоор нь хятад үгийн Ху яриангүй мөн бөгөөд өөрөөр хэлбэл Хүн-ээс иржээ. Үүнээс үзэхэд Төвд, перс сурвалж бичгүүдэд эрт үеийн Хүн хэмээх нэрийдэл болон хожим үеийн Түргүүд хэмээх нэрийдлийг хэрэглэх талаар адилгүй боловч Хүн, Түргүүд, Монголыг нэг угсаа төрлийн хүмүүс гэж үздэг талаар адил байжээ.

«Огус хааны тууль»-д Монгол гэдэг нэр дурдагдаагүй юм. Рашидын номд монгол хэмээх нэр нь түргүүдээс хол хойно үүссэн гэдэг. Одоо Монгол болон Хүн-Түргүүдийн мах цусны холбоог өгүүлэх хэрэгтэй байна.

Рашид өөрийн «Судрын чуулган»-даа Хүн-ээс таван зуу орчим жилийн дараа хүчирхэгжин мандсан түргүүдийн нэрээр эрт дээр үеийн Хүн гэдэг нэрийг орлуулсаны хамт Абулжа хаан болон түүний хүү Див Яхуйг Түргүүд-Монголын нийтийн дээдэс мөн байсан, Түргүүд болон Монголын өнгө зүс, үг хэл нь хэдийгээр ялгаатай боловч Монгол нь Түргүүдийн нэгэн хэсэг мөн гэж дахин давтан бичсэн байжээ. Дээр дурдсан Див Яхуйг бас Див Бахуй хэлдэг, «Яхуй буюу Бахуй» нь «Олон аймгийн ноён» гэсэн утгатай гэжээ. «Див» гэдэг үгийн утга агуулгын тухай эрдэмтдийн санаа адилгүй байна. Миний үзэхээр «Див» нь «Төв» гэдэг үгийн адил бус бичлэг байж мэднэ. Учир нь Төв Яхуй гэдэг нь Төвийн аймгуудын ноён гэдэг утгатай мөн Төв Яхуйг өөрийн эцэг Абулжа хаан эрдэм чадвар, эрэлхэг баатарын хувьд хол илүү байсан гэсэнтэй нийцдэг юм. Хүн Түргүүд-Монгол нийтийнхэн хоёрдугаар үеийн дээдэс Төв Яхуйн үед, өөрөөр хэлбэл одоогоос тав, зургаан мянган жилийн өмнө тэд нарын төвд төвлөрсөн эрхт хаант улс эхлэн бүрэлдэн тогтоод хүн төрөлхтөний боловсон түүхийн үе шатанд шилжин орсон бололтой. Төв Яхуй нь Хар хаан, Оор хаан, Гүр хаан, Гүс хаан гэсэн дөрвөн хүүтэй. Тэд нарын үеэс эхлэн хойт зүг, зүүн хойт зүг, баруун хойт зүгийн газар нутгийг тус тус эзэлсэн гэнэ.

Хүн-Түргүүд-Монголын дээдсийг их говийн өмнөх нутгаас хүчирхэгжин мандсан гэж үзвэл, Рашидын бичсэн зүг чиглэлээр тэд нарын газар нутаг нь одоогийн их говийн ар, зүүн хойт нутаг, тэнгэр уулын ар өвөр /дээд доод болон дундад азийн өргөн уудам нутаг

яриангүй мөн. Хар хааны хүү Огус хааны үед тэд шинээр эзэлсэн газар нутгаа нэгтгэхээр оролдсон бололтой. Рашидын номд тэмдэглэснээр Огус хаан өөрийн эцэг Хар хаан болон гурван авга Оор хаан, Гүр хаан, Гүс хаантай газар нутаг, цэрэг иргэдээ булаацалдаж олон жилийн дайн байлдаан болоод эцэст нь Хар хаан алагдан цэрэг, иргэд нь Огус хааны захиргаан дор ороод Оор хаан, Гүр хаан, Гүс хаан зүүн тийш дорно зүг нүүж Монголын олон овог, аймгийн дээдэс болсон гэнэ. Рашидын номд XIII зуунаас өмнөх монголчуудыг язгуур монгол, тал нутгийн монгол гээд гадаад дүр төрх, үг хэлээр монголтойгоо адилавар мөртлөө эртнээсээ тусгай нэртэй байсан монгол гэж гурав хуваадаг. Эртнээсээ тусгай нэртэй байсан монголын дотор Гүрлигүүд гэдэг аймаг байжээ. Мөн зарим монгол сурвалж бичигт, одоо болтол монголыг Оор монгол гэж бичиж тэмдэглэж байгаа.³² Миний үзэхээр Оор монгол болон Гүрлигүүд аймгийн нэр нь огус хааны авга нар байсан, дээр дурдсан зүүн тийш дорно зүгт нүүдэллэсэн Оор хаан, Гүр хааны хойчис байжээ.

«Огус хааны тууль»-д хэдийгээр монгол гэдэг нэрийг дурдсангүй боловч Зүрчин хэмээх нэрийн утга болон Огус хаан Зүрчидийг дайлсан түүхт үйл явдлыг нэлээд тодорхой өгүүлсэн юм. Зүрчин гэж тариалаагүй атар тэгш талгазрыг хэлэх, энэ нь Их Хянганаас зүүн тийш орших тэгш тал газрыг хэлсэн нь яриангүй мөн. Огус хаан Зүрчиний хааныг алж түүний эд хогшлыг ард иргэдийг нь өндөр аралт хинган тэрэг хийж тээвэрлэсэн гэж дээр өгүүлсэн билээ. Эдгээрээс үзэхэд хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн . Зүүн ху /Дун ху/ нь одоогоос тав, зургаан мянган жилийн өмнө Огус хааны гурван авга нарын захиргаанд байсан овог аймгуудын нийтийн нэрийдэл байжээ. Хүн болон Зүүн Ху бүр Абулжа хаан, Төв Яхуйн угсааны хойчисын захиргааны овог аймгууд мөн. Өөрөөр хэлбэл Абулжа хаан Төв Яхуй бол Хүн-Түргүүд Монголын нийтийн өвөг дээдэс болно. Хэдэн мянган жилийн өмнөх Хүн болон Зүүн Ху-г адил бус хоёр угсаа үндэстэн гэж хэлж болохгүй юм. Рашидын «Судрын чуулган»-д тэмдэглэсэн эдгээр зүйлүүд нь XIII зууны үеийн Болд чинсан нарын Түргүүд-Монголын алдарт түүхчид, туульчид, үлгэрчид нарын хэлснийг үндэслэл болгосон, эсвэл ямар нэгэн ховор нандин сурвалж бичгийн тэмдэглэлийг үндэслэж бичсэн байх ёстой. Тийм биш бол эмч гаралтай перс хүн дээрх зүйлүүдийг мэдэх аргагүй юм. Эдгээрээс үзэхэд долоон зуу гаруй жилийн өмнө Монгол хаант улс хүчирхэгжин мандаж байсан тэр үед монолчуудын үе улиран дамжиж ирсэн өөрсдийн гарал үүсэл, язгуур дээдсийн тухай баримт ишлэл нь одоогийн зарим түүхчдийн дутуу дулимаг судалгаа, өрөөсгөл үзэл, харь үндэстний эрх ашгийн байр сууринаас бичиж байгаагаас хол илүү үндэслэл, итгэл их үнэн зөв байх ёстой.

Рашидын «Судрын чуулган»-д Түргүүд-Монголын язгуур дээд нь нэг гэснээр үл барам, Монголын ноён аймаг болох Хияд ч Түргүүдээс, нэн оновчтой хэлбэл Хүн-ээс салсан гаралтай гэдэг юм. Олны мэдээжээр Хияд бол Чингис хааны алтан ургийн аймгийн нэр юм. Тэр нь уулнаас доош түргэн урсах их үерийг хэлдэг гэнэ. Хияд аймгийнхан эрэлхэг баатар эрс хатуу, чийрэг болохоор тэгж нэрлэсэн байжээ. XIII зуунд Рашид Түргүүд-Монголын «Эргүнэ Хуны домог»-ыг үндэслэн бичсэн нь:... тэр үеэс их төлөв хоёр мянга гаруй жилийн өмнө, хожим үед монгол гэж нэрийдсэн тэр аймгийн хүмүүс нь Түргүүдийн бусад аймгийн хүмүүстэй муудалцаж сүрхий их дайн байлдаан болоод олонхи нь алагдаж зөвхөн Хиян, Нэгүс хоёр хүн, хоёр эмэгтэйн хамт их хянганы Эргүнэ Хуны их ой шугуйт газар зугатан орж амьдраад хожим хүн амын тоо нь их өсчээ.³⁴ Энэхүү Хиян болон Нэгүс даруй язгуур Монголын дээдэс мөн юм гэжээ. Хияд гэдэг нь Хияны олон тоо билээ. Нэгүс аймгийн хүмүүсийг заримдаа Чинуус гэдэг.³⁶ Чинуус гэдэг нь Хүн-Түргүүд-Монголын нийтийн онгон шүтээн Чинува /Чоно/-гийн олон тоо билээ. Үүгээр үл барам Рашидын номд «Монголын нууц товчоон»-той адил Чингисийн язгуур дээдсийг мөн Бөртэ чоно, Хуа Марал гэж тэмдэглэжээ.³⁶ Эдгээр нь бүгд ХҮИ-ХИХ зууны үеийн Монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэсэнтэй их төлөв адил юм. Адилгүй газар гэвэл: Рашидын бичсэн язгуур монгол нь Түргүүдийн бусад аймгуудтай муудалцсан гэдгийг ХҮИ-ХИХ зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд өөрчлөн Энэтхэг, Төвдийн хаад буюу түшмэдийн хоорондоо муудалцсан гэж бичжээ.

Энэ нь шарын шашны хутагт хувилгаандаас Чингисийн алтан урагтанг Энэтхэг, Төвдийн хаадаас гаралтай гэдгээ хүмүүст итгүүлэх гэсэн оролдлого яриангүй мөн. Энэ тухай тодорхой хэлбэл: зохиогчийн нэргүй «Алтан товч», Лувсанданзангийн «Алтан товч», Лоолийн «Монголын Боржигид овгийн түүх», Дармаа Гүүшийн «Алтан хүрдэн мянган хэгээст» болон «Асрагч нэртийн түүх»-д бүр Энэтхэгийн Махасамади хааны хойчис-Төвдийн Алтан сандалт хааны гурван хөвгүүд хоорондоо муудалцаж отгон хүү Бөртэ Чоно хойш зүг тэнгис далай гаталж Жэд-ын газарт ирээд эргүй Хуа маралыг гэргий болгон аваад монгол овогтон болов гэдэг юм. Ингэхдээ монгол овогтонг бас монгол аймаг гэж хэлэх бөгөөд тэд нарын зугатаж очсон газрын нэр Жэд гэдгийг бас Зэд буюу яд гэж адил бусаар бичдэг. Тоба тайжийн «Шар тууж», Саган Сэцэний «Эрдэнийн товч» болон Жамбалдоржийн «Болор толь»-д Төвдийн алтан Сандалт хаан нь Луннам нэртэй түшмэлдээ хороогдсонд түүний отгон хүү Бөртэ Чоно, Хуа Марал гэргийгээ аван дорно зүг тэнгис далай гатлан Бэтэ улсад золгосонд Бэтэ-гийн улс хотлоор зөвшилдөн түүнийг язгууртаны хүү гэж ноён өргөмжилсөн гэдэг юм.

Эртний хятад сурвалж бичгүүдийн тэмдэглэснийг харвал МЭӨ 209 онд Мэ 91 онд хаан эцгээ хороогоод хаан болоод Хүн

болон Зүүн-Ху хоорондоо муудалцаж их дайн байлдаан болж Зүүн Ху-гийн доторхи зарим хэсэг нь Сяньби ууланд зугатан орж түүнийг батлан хамгаалагчид нь Сяньби болж У Хуань ууланд зугатан гарч түүнийг батлан хамгаалагчид нь У Хуань болсон гэдэг. Ингээд Рашидын «Судрын чуулган»-д бичсэн язгуур монголын гарал үүсэл. ХҮИ-ХІХ зууны монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн монгол овогтон буюу Монгол аймгийн гарал үүсэл, эртний хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Сяньби, У хуаний гарал үүсэл зэрэг нь бүр нэг л түүхт үйл явдлыг өгүүлж байв. Юу гэвэл: язгуур монгол, Монгол овогтон, монгол аймаг болон Сяньби зэрэг хэллэг адилгүй боловч тэд бүгд л дотоодын дайн байлдаанаас болоод ямар нэгэн газар орныг батлан хамгаалж тусгаарласан байжээ. Монголын гарал үүслийн талаар ХҮИ-ХІХ зууны монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн түүхэн цаг үе нь тодорхойгүй боловч Рашидын «Судрын чуулган» болон эртний хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн түүхэн цаг үе нь их төлөв адил бөгөөд бүр л МЭӨ хэдэн зуун жилийн хэрэг явдал билээ.

Эртний хятад сурвалж бичгүүдэд Монгол, Түргүүдийн нийтийн хэдэн үеийн дээдсийн нэр болон Эргүүна Хуны газарт зугатан очсон овог аймгийн нэрийг бодитой дурдаагүй боловч Рашидын «Судрын чуулган»-д тэмдэглэсэн Чинуус, онцлон Бөртэ Чоно болон Хуа Марал нь ХҮИ-ХІХ зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэсэнтэй адил байжээ. Бөртэ Чоно бол Хүн-Түргүүд Монголын нийтийн сүлд шүтээн гэдгийг энд дахин тэмдэглэе. Үүгээр үл барам хятад сурвалж бичгүүдэд Хүн-ий язгуур овгийг мөн өөр үсгээр Ху Янь, Чингисийн аймгийн Хиянь гэж тэмдэглэсэн нь бүр эртний Хиян гэдэг үгийн адил бус авиачилсан бичлэг тэмдэглэл гэж үзвэл зүйтэй юм. Монголын нууц товчоон»-ы тэмдэглэлийг үндэслэвэл монголын Хиян аймгийн сүлд шүтээн нь цагаан шонхор билээ. Монголчууд эртнээс дал-ны махыг даяар идэх гэдэг мөртөөн дал-ны төлөг гэж үздэг юм. Зарим нутагт далны ясыг дээр хадгалж тусгайлан далны найр цуглаан хийдэг ч буй. Төвд сурвалж бичгүүдэд монголыг Согбо гэдэг нь далчин гэдэг утгатай юм. Рашидын «Судрын чуулган»-д тэмдэглэсэнээр Хүн хааны дөрвөн хүүхдийнхэн. сүлд шүтээн нь мөн цагаан шонхор бөгөөд төрийн найр хурим, тахилга, тайллаганд далын мах олж хүртдэг онц эрхтэй. Хүн хааны ахмад хүүг Хан гэдэг нэртэй бөгөөд тэр нь мөн монголын Хиянтай адилаар эрс чийрэг гэдэг утгатай гэнэ. Тэгвэл Чингис хааны аймгийн нэрийдэл Хиян нь Огус хааны ач, Хүн хааны ахмад хүүгийн нэр Хан-аас ирсэн байх ёстой. Гэвч сонирхолтой нь Хан-гийн гэр бүлийнхэн далны мах олж хүртэх онц эрхтэй байсан гэхэд Монголын Хиян нь далын махыг даяар идэх гэдэг ажээ. Бодоход: МЭӨ 209 оны урьд хожид Хүн болон Зүүн Ху-гийн хооронд хожид Хүн болон Зүүн Ху-гийн хооронд эрх ашгаа булаацалдаж дайн байлдаан хийсэн явцад Хүн хааны ахмад хүү Хан-гийн хойчисын зарим нь зүүн Ху-гийн талд байж

эцэстээ ялагдаад Хүн хаант улсаасаа хагацаж Хянганд нуруунд зугатан очиж Оор хааны хойчист ноён өргөмжлөгдөж монголын Хянд аймаг болжээ. Ингээд Хянганд нурууны Монголыг угаас хэлдэг Ниругун, Хянд ниругун гэж хоёр хэсэг болгон нэрийддэг. Хянд Ниругуныг бас Хянд Ясар, Хянд Боржигон буюу Бор нүдэт Хянд гэдэг юм. Хийд ясар гэдэг нэрийдэл нь Огус хааны хоёрдугаар хүү Ай Сараны ахмад хүү Ясарын нэрээс иржээ. Ясар гэдэг нь олон талаар бишрэн дагах гэсэн утгатай юм.³⁸ Хянд Боржигон буюу Бор нүдэт Хянд гэдэг нь Хинд Ясараас хол хойно Буданцарын үед үүссэн нэрийдэл байх. Үүнээс үзэхэд Хянд, Ясар гэдэг нь Хүн хааны хоёр хөвгүүний нэр Хан болон ясараас иржээ. Одоо цагийн зарим эрдэмтэд Түргүүд, Монголын язгуур дээдсийг адил бус угсаа үндэстэн, хянганд нуруунд амьдарч байсан үеийн язгуур монгол нь он сар, ан гөрөө хийдэг хонь тэжээхийг мэдэхгүй байсан гэж хачин жигтэй юм ярьдаг болжээ.

Язгуур монголын дээдэс нь монголын тал нутгаас Хянганд нуруунд зугатан ороод өнгөрсөн боловсон соёлоо бүрмөсөн мартаж, гадаад орчинтой харьцаа холбоогоо бүрмөсөн таслах ёсон алга. Язгуур Монголыг хонь тэжээхийг мэдэхгүй байсан гэж хэлэхийн оронд Хянганд нурууны битүү ой шугуйт нутагт хонь тэжээхэд тохиромжгүй байсан гэж хэлэх нь үнэнд ойртох байсан. Рашидын «Судрын чуулган»-д тэмдэглэсэн язгуур монголын гарал үүсэл, ХҮИ XIX зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн монгол овогтон буюу монгол аймгийн гарал үүсэл, эртний хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн У хуань, Сяньбигийн гарал үүсэл зэрэг нь бүр нэг л түүхт үйл явдлыг хэлж байснаар үл барам Хянд болон Нэгүсийн зугатан очсон Эргүүнаа Хуны газар, Бөртэ-Чонын хэсэг очсон Жэдын газар, , Зүүн Ху-гийн хэсэг хүмүүсийн батлан хамгаалсан Сяньби уул зэрэг нь мөн л нэг л газрын адил бус нэрийдэл байсан бөгөөд тэр нь хянганд нуруу мөн юм.

1980 онд хуучид судлаачид одоогийн Өвөр Монголын Хөлөн буйр аймгийн Орчон хошууны төв Алин гол балгасны ойролцоо гацаа тосгоны Гацаа агуйгаас эртний Төба Сяньбигийн дээдсийн тахилгын орон байсан Чулуун өргөөн дэхь хятад үсгийн бичээсийг шинээр олоод эртний хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Сяньби уул гэдэг нь хянганд нуруу мөн гэж нотолсон юм. Одоогийн монголчууд Хянганд нурууг бас Хянганд уул буюу хянганд даваа гэж хэлдэг. Эдгээр нь бүр эртний Хянганд шилбэ гэдэг нэрээс улирч хувирч иржээ. Хянганд шилбэ гэж хянганд нурууны гадаад хэлбэр дүрс нь хянганд шилбийн ясны хэлбэртэй болохоор тэгж нэрийдсэн байх аа. Эртний Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Сяньби, Шивэй нь бүр шилбэ гэдэг үгийн адил бус авиачилсан тэмдэглэл билээ. Монголын нууц товчоон»-д Хянганд нурууг «Харахун жидун» гэж нэрлэдэг. Чин улсын үеийн Манж сурвалж бичгүүдэд Харахун жидунгийн «Жидун»-г олонхидоо «жадун» гэж бичдэг. Дагуур монголчууд одоо ч хянганд

нурууг «Жидийн даваа» гэж нэрлэсээр байгаа. Тэгвэл ХҮИ-ХИХ зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэн «Жэд», «Жад», «Яд» болон манж сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэн «Жадун», Дагуур монголчуудын хэлдэг «Жид» зэрэг нь бүр «Монголын нууц товчоон» д тэмдэглэгдсэн «Жилун» гэдэг үгийн адил бус бичлэгүүд мөн. «Жидун» мөн «Нуруун» гэдэг утгатай юм. Харахун жидуныг Хар уул, Хар хад, Хар даваа гэж ойлгож болно.

Рашидын «Судрын чуулган»-д тэмдэглэсэн Залайр /Жалайр/ аймгийн доторхи «Жад» хэмээсэн овог нь мөн жидун гэсэн үгнээс ирсэн байж мэднэ. Мөн тус номд тэмдэглэсэн Эргүүнэ Хуны газар гэдэг нь дээш өргөгдсөн уулархаг газрыг хэлж байгаа юм. Энэ нь Эргүүна голын зүүн талд орших Хянган нурууны дээд хэсэг газар өөрөөр хэлбэл Төба Сяньбигийн тахилгын орон Гацаа агуйн ойролцоо нутгийг хэлж байна. Ийнхүү Сяньби уул, Эргүүна Хун, Жадын газар нь үнэндээ бүр Хянган нурууг хэлж байсан ажээ. МЭ 91 онд умард Хүн-ий гол хүчин баруун тийш дундад Ази руу нүүдэллэснээс эхлэн Сяньби Шилбийн овог аймгууд хянган нуруунаас урд хойно бууж баруун тийш говийн арын тал нутаг, өмнө тийш Шар мөрний урсгал дагуу газраар, өөрөөр хэлбэл хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн мянган газрын нарсат элсийг эзлэн нутагшжээ. Үүний хамт баруун тийш дундад Ази руу нүүдэллээгүй, монголын тал нутагт үлдэж хоцорсон Хүн-ий хэдэн арван түмэн хүмүүс ч өөрсдийгөө Сяньби Шилбэ гэж хэлдэг болжээ. Сяньби Шилбэ гэдэг нэрийдэл анх эхлэхдээ зөвхөн Хянган нурууны хүмүүсийг хэлдэг байсан бол МЭ 2 4 дүгээр зуунаас монголын өндөрлөг дэхь олон овог аймгийн нийтийн нэрийдэл болжээ. Мөн тэр үеийн /МЭ 2-4 зуун/ хятад сурвалж бичгүүдэд говийн арын овог аймгуудыг нийлэм Сяньби, Шар мөрний урсгал дагуу нутаг орны овог аймгуудыг Ляо дүнгийн Сяньби, Ляо Сигийн Сяньби гэж нутгийн зүүн, баруунаар нь ялгадаг байжээ./Ляо-гэдэг үг нь шар мөрний нэг хэсгийг Луухийн гол гэдэг үгийн эхийг авиачлан тэмдэглэсэн үсэг юм.МЭ 220-265 оны үед сяньби Шилбийн сүр хүчин говийн өмнө өргөжин тэлж хуучин Шар мөрний урсгал дагуу нутгийн Сяньби Шилбийг Зүүн этгээдийн Сяньби, одоогийн Алашаа, түүний өмнөх орны Сяньби Шилбийг баруун этгээдийн сяньби, говийн ар, өврийн Сяньби Шилбийг Төба сяньби гэж нэрийдэх болжээ. МЭ 317-589 оны үед дотор газрын хятадын сүр хүчин, доройтсоныг далимдуулан Монголын өндөрлөг дэхь Хүн, Түргүүд, Сяньби Шилбийн олон овог аймгууд дотор газар руу цөмрөн ороод урьд хожид бүгд арван зургаан улс байгуулжээ. Тэр үед одоогийн Хөх хотын өмнө орших Шэн-л хотоор төвөө болгосон говийн өмнө олон овог аймгуудыг Төба Сяньби, Говийн арын овог аймгуудыг Ру-рань, Шар мөрний урсгал дагуу нутгийн овог аймгуудыг Гидан-Гидан /Хидан-Хидан бөгөөд Ку-мэ-хи, ууган нутаг Хянган нуруундаа үлдэж хоцорсон овог аймгуудыг Ү-лөхэу гэж ялган нэрийдэж байжээ. Дээр дурдсанаас үзэхэд Сяньби Шилбийн олон

овог аймгуудын тухай хятадуудын мэдлэг нь эхлээд их бүдэг балархай байсан бөгөөд Сяньби Шилбийн олон аймгууд өмнө зүгт нүүдэллэхийг дагалдаж аажмаар тодорхой болсон ажээ. Гэтэл одоо ч зарим эрдэмтэд дээр дурдсан Сяньби Шилбийн олон овог аймгуудын нэрийдлүүдийг элдвээр тайлбарласан тэднийг адил бус угсаа үндэстэн гэж хэлж байгаа нь буруу юм. Одоо дээрх дурдсан зарим нэрсийг тайлбарлъя. Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Төба Сяньби-гийн Төба- гэдгийг МЭ 732 онд Түргүүд үсгээр бичигдсэн «Гүл-тигиний хөшөө»-д «тавгача», XI зууны үед зохиогдсон Махамуд Хашихарын «Түргүүд их толь бичиг»-д «таваш» гэж бичжээ «Тавгача» болон «тавгаш» нь «тав» болон «гача» буюу «гаша» гэсэн хоёр үгнээс бүтжээ. Төба Сяньбигийн Хянган нуруун дахь дээдсийн тахилгын орон нь Гачан агуй гэж дээр дурдсан билээ. «Гача», «Гаш», «Гачан» нь бүр одоогийн хэрэглэж байгаа «Гаца» гэдэг үгийн адил бус бичлэг мөн бөгөөд гацан агуйн нэрээс үүсжээ. Тэгвэл Төба сяньби нарын хянган нуруунаас буухын өмнөх нэр нь «Гачахаа» гэж байсан бөгөөд тэр нь Гачан агуйн нэрээс үүсчээ. МЭ I зууны үед умард Хүн-ий гол хүчин баруун тийш нүүдэллэхийг дагалдан Гачахаа-гийн олон овог аймгууд хянган нуруунаас бууж говийн арын төв нутагт нутагшаад «Тавгача» гэж нэрлэгдэх болжээ.»Тавгача» гэдгийн «тав» нь төв гэдэг үгийн адил бус бичлэг байжээ. Дөрвөн зуу гаруй жил өнгөрөөд МЭ : 443 онд Тавгача-гийн байгуулсан, хятад түүхэнд умард Вэй улс гэж тэмдэглэгдсэн улсын хаан нь Ү-лөхэу аймгийн элчээс өөрийнхөө дээдсийн тахилгын орон-Гача агуйн байдлыг сонсож мэдээд тусгай элч явуулж тахилга тайллага хийлгээд агуйн ханан дээр үсэг сийлэн үлдээсэн юм. Бодоход Ү-лөхэу гэдэг нь «Өргөө» гэдэг үгийн авиачилсан тэмдэглэл болох бөгөөд тавгачатай дээдэс нэгтэй байх. Учир нь гацага, өргөө хоёр нэрийдэл утга ойролцоогоор үл барам Гацаа агуйн орчин тойрны газар нутаг нь Гацаачуудын дараа нэлээд урт хугацаанд өргөөчүүдийн нутаг болжээ. Түүхэн дээр тавгача аймаг нь умард Вэй улсыг байгуулснаар үл барам хятад нь феодализмын үед хамгийн хүчирхэг мандсан Тан /МЭ 618-936 улсын хааны угсаа ч түүнтэй мах цусны холбоотой байж мэднэ. Учир нь МЭ 220-589 оны үед умардын угсаа үндэстнүүд болон дотор газрын хятад үндэстэн хоорондоо дахин нэг удаа харилцан холилдон шингээд хятад үндэстэн нь өнгөрснөөсөө өөрчлөгдөн холимог болсон байжээ. Дээр дурдсан Түргүүд үсгийн «Гүл-тигин»-ний хөшөөнд мөн тэр үеийн дундад азийн улс үндэстнүүд хятад нутгийн Тан улсыг Тавгача гэж нэрийддэг байжээ.

МЭ IY зууны сүүлчээр говийн арын Ру-ран хүчирхэгжин мандсан билээ. Гадаадын сурвалж бичигт Ру-раныг «Авара» гэж бичдэг юм. Миний үзэхээр Ру-ран нь «аран» буюу «араар» гэдэг үгийн авиачилсан тэмдэглэл юм. «Аран» гэдэг нь хоорондох гэдэг утгатай үг юм. Говийн арын Аран хаант улс нь тухайн үеийн Байгал нуурын орчин тойрны Түргүүд болон говийн өмнөх Тавгача Вы улсын

хооронд нутагшиж байсан болохоор тэгж нэрлэсэн бололтой. Хятад сурвалж бичгүүдэд Сяньбигийн өмнөх, өөрөөр хэлбэл хянган нуруунаас өмнөхийг Гидан /Хидан/ гэдэг Түргүүд үсгээр Гидан /Хидан/ -ийг Гидай /Хидай/ гэж бичдэг. Монголчуудын одоо болтол хэрэглэж байгаа хятад гэдэг нэрийдэл хиданаас иржээ. Оросууд мөн монголчуудыг дагаад Китай гэж байна. Хидан, Хидай, Хятад гэдэг үгийн үндэс нь «Хи» бөгөөд тэр нь бага буга гэсэн утгатай юм. Хүн-Түргүүд-Монголчууд түүхэнд хүчирхэгжин мандаж байсан үест тэд нарын гол цогц цөм нь болж байсан овог аймгууд болон гол үйлдэл гаргасан түүхт хүмүүсээ чоно-Бори / Бор буга Хи буюу Или гэж нэрийддэг байжээ. МЭ 552 онд Түргүүд хаант улсыг байгуулсан Түмэн хааны цол-Или ч бага бугийн зулзага гэсэн утгатай юм. 563 онд Түргүүд хаант улсын баруун тэнгэр уулын ар, өвөр болон дундад Азийн газар нутагт нутаглаж байсан Бори /Бор/ хааны «Бори» нь ч «Чоно» гэдэг утгатай ажээ. Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэснийг үндэслэвэл, Гидан /Хидан/-тай зах нийлж зэргэлдээ Шар мөрний урсгал дагуу мянган газрын нарсаг элст нутагт малжиж байсан хятадаар Ку-му хи гэж тэмдэглэгдсэн овог аймгууд бол нугун шилбэ /Нуун шилбэ, Хүн-ий хойчис бөгөөд Зүүн Ху-гийн хойчис биш юм. Хятад сурвалж бичгүүдэд Ку-мухи гийн Хи гэдэг үсгийг мөн хи, ши гэж хоёр үсгээр товчлон тэмдэглээд адил бус хоёр хэсэг хүмүүсийг хэлдэг байжээ. Ку-му хи нь монголын «Хомохи» гэдэг үгийн авиачилсан тэмдэглэл юм. Учир Хомохи аймаг нь Шар мөрний урсгал дагуу нарийн элстэй газар нутагт малжин амьдарч байсан болохоор тэгж нэрлэсэн юм. Түүний чухам нэрийг нь «Дадбэй» гэдэг. Одоо зарим эрдэмтэд Хомохи гэдэг нэрийдлийн улиран хувирсныг үл хайхран «Хи», «Ши»-г хоёр өөр угсаа үндэстэн гэж үзэж тэмдэглэсэн буруу юм. Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Сяньби болон Шивэй бол нэг нэрийн адил бус авиачилсан тэмдэглэл мөн гэж Францын нэрт монголч эрдэмтэн Пеллио анх түрүүнд дурджээ. Гэвч тэр Сяньби болон Шивэйг шилбэ гэж сэргээж чадаагүй. Харин «Сэрби», «Ширби», «Ширэй»-н авиачилсан тэмдэглэл болох байхаа гэж таажээ. Монгол бол Шивэй Шилбийн доторхи нэгэн аймаг болжээ. Үү зууны сүүлч, Тавгача Вэй улсын үеэс эхлэн Хятад сурвалж бичгүүдэд Хянган нурууны орчимд байсан овог аймгуудыг Сяньби нараас ялган Шивэй гэж нэрийддэг болжээ. Сяньби болон Шивэй нь хэдийгээр цөм Шилбэ гэдэг үгийн авиачилсан тэмдэглэл боловч энэхүү хоёр нэрийдлээр түүхийн адил байсан бус үеийн Хянган нуруунд амьдарч байсан овог аймгуудыг ялган нэрлэж байжээ. Уул нь Сяньби Шилбэ, Шивэй Шалбэ гэсэн бол бүр ч зүйд нийцэх байжээ. Хятадуудын Шивэй Шилбийн тухай мэдлэг ч аажмаар нэмэгджээ.

МЭ ҮI зууны сүүлчээс хятад сурвалж бичгүүдэд Шивэйг Их Шивэй, Умард Шивэй, өмнөт Шивэй гэж хүн амын олон цөөн, оршин суудаг зүг чигээр нь ялган нэрийддэг болжээ. Мөн Хар мөрнөөс

хойгуур гадаад хянган нуруунаас өмнө нутагладаг овог аймгуудыг . Бөвөө Шивэй, Шэньмэгэн Шивэй гэж нэрийддэг байжээ.

МЭ 945 онд зохиогдсон «Хуучин Тан улсын бичиг»-т Шивэй Шилбийг есөн аймаг гэжээ. Гэвч үнэндээ найман аймаг байсан юм. Есөн аймаг гэж Түргүүд-Монголын заншлаар Шивэй Шилбийн бүрэн гүйцдийг бэлгэдэн хэлснээс биш, бодит тоо биш юм.³⁹

Хятад сурвалж бичгүүдэд Шивэй Шилбийг Гидан /Хидан/-ыг төрөх угсаатан гэж тэмдэглэснээс гадна Тавгача Сяньби луга дээдэс нэгтэй Өргөө -ийг ч Шивэй Шилбийн дотор оруулж тооцдог байжээ. «Хуучин Тан улсын бичиг»-т Шилбийн овог аймгуудын газар зүйн байршлыг тэмдэглэхдээ: Тэд нарын хамгийн баруун захад нь Хөлөн нуурын баруун өмнө Уйгур лугаа нийлдэг нь Өсгүү /үсгүү/ аймаг, Монгод аймаг бол Эргүүнаа голын зүүнээр нутагладаг гэжээ.Энэ нь Монгол хэмээх нэрийдлийн хамгийн анхны тэмдэглэл билээ. Үүнээс үзэхэд Тан улсын эхний үеэс эхлэн монгол хэмээх нэр түүний орчин тойрны овог аймгуудын дунд алдаршиж дотор газрын хятад хүмүүс ч түүнийг эхлэн тэмдэглэх болжээ.

Рашидын «Судрын чуулган»-д Хиян болон нэгүсийг язгуур монгол гэж тэмдэглэсний хамт монгол хэмээх нэрийдлийг Түргүүдээс нэлээд хойно үүссэн гэжээ.⁴⁰ Тэгвэл Монгол хэмээх нэрийдэл нь МЭӨ II зуунаас МЭ VI зууны хооронд Эргүүнаа Хун-ы газарт үүссэн байх ёстой.XIII зуунаас одоо болтол дэлхийн монголч эрдэмтэн монгол нэрийдлийг элдэв янзаар тайлбарласаар иржээ. МЭ 945 онд зохиогдсон «Хуучин Тан улсын бичиг»-т анх монгол хэмээх нэрийдлийг бичиж тэмдэглэснээс эхлэн XIII зуунд монгол хүчирхэгжин мандах хүртэлхи гурван зуу гаруй жилийн хугацаанд Хятадын олон сурвалж бичгүүдэд монгол хэмээх нэрийдлийг бараг хориод янзаар авиачилан тэмдэглэсэн байжээ. Тэдгээр хятад үсгийн адил бус авиачилсан тэмдэглэлийг харилцан харьцуулан юуны өмнө монгол гэдэг үгийн үндэс дагварыг тодлоод дараа нь холбогдол бүхий монгол, перс сурвалж бичгүүдийг талбарласныг үндэслэн монгол гэдэг үгийн утга ухагдахууныг зөв ойлгож болох юм. Хятад үсгээр авиачлан тэмдэглэсэн тэдгээрээс төлөөлөх чанартай хэдийг сонгон аваад эртний хятад үсгийн авиагаар уйгуржин монгол бичгээр сэргээвэл монгол/, /монгос, /монгол монгор, монго/ зэрэг болно. Эдгээрээс монгол гэдэг үгийн үндэс нь «мон» бөгөөд түүний дотор олон тооны дагавар «д, с, л» буюу Түргүүд-Монголын үг бүтээх дагавар «р»-ыг залгаж нэр үг бүтээжээ гэж амархан мэдэж болох юм. Харин «Го»- нь үг найрлагын хэрэгцээнээс нэмэгдэнэ. Монгол хэлэнд ийм жишээ тоогүй олон буй. Монголыг манжаар «Монхо» гэж бичдэг юм. Бодоход XII-XIII зууны үеийн манжийн дээдэс зүрчдийн хэлэхийг дагаж хятадаар «Мон-гү» гэж бичих болжээ.

Рашидын «Судрын чуулган»-д Монгол гэгчийг «буурай, асвар» гэсэн утгатай гэж тайлбарлажээ. «Монголын нууц товчоон»-д «Мон»

гэдэг үгийн хажууд хятадаар «Хүчир гачигдал» гэж орчуулсан байдаг. Монголчууд одоо болтол хүчир гачигдалтай амьдарч байгаа хүмүүсийг мунгинаж байна гэж хэлдэг юм. Тэгвэл монгол хэмээх нэрийдэл нь язгуур монголын дээдэс, Хиян болон Нэгүс нь саруул сайхан тал нутагт нүүдэллэн малжин амьдарч байснаас Эргүүнаа Хун-ы ой шугуйт газарт зугатан орж хүчир гачигдалтай амьдрах болсныг тусгаж нэрлэжээ. Гашууны дараа амт гэж байдаг, зовлонгийн дараа жаргал байдаг. Энэ бол хүн төрөлхтөний жам ёс билээ. Эдгээрийг үл анхаарч, зарим санаа сайтай эрдэмтэд монгол хэмээх нэрийдлийг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт асч байдаг мөнх гал буюу хүн төрөлхтөний өнө үүрдийн мөнх гол төв хэмээн тайлбарлаж байхад бас зарим муу санаатай нь монгол гэдэг нь мунхаг, мангас гэдэг утгатай хэмээн доромжлон хэлдэг ч буй. Гэвч эрдэм шинжилгээний асуудал бол хүмүүсийн зориг санаа, хүсэл эрмэлзлээр шийдэгдэх зүйл биш юм. Рашидың «судрын чуулган»-д XIII зуунаас өмнөх монголыг язгуур монгол, тал нутгийн монгол, тус бүрдээ онцгой нэртэй байсан монгол гэж гурван хэсэг болгон тэмдэглэсэн гэж дээр өгүүлжээ. Эдгээр гурван хэсэг монгол нь Огус хааны ноёрхолд ороогүй, харин түүний 3 авга Оор хаан, Гүр хаан, Гүс хаан болон тэд нарын хойчисын захиргаан доторхи овог аймгууд гэдэг юм. Язгуур монголын хүчирхэгжин мандахыг дагалдаж бусдууд нь ч тэднийг дагаж өөрсдийгөө бүр монгол гэж нэрийдэх болжээ. Тал нутгийн монголын олон овог аймгууд хэдийгээр угсаа төрөл, хэл яриагаараа язгуур монголтойгоо ойролцоо боловч өнгөрсөндөө тус тусын хаан ордон, газар нутагтай байсан бөгөөд язгуур Монголтойгоо тийм их харьцаа, холбоо байсангүй гэнэ. Гэтэл XIII зуунаас өмнө тус бүр нь онцгой нэртэй байсан монголын олон овог аймгуудын дүр төрх, хэл яриа нь язгуур монголтой адилавар бөгөөд тэд нар хоорондоо нягт харьцаа холбоотой байжээ. Гэвч он жил хэтэрхий удсан болохоор язгуур монголоос гадна бусад хоёр хэсэг монголын олон овог аймгуудын язгуур гарлыг тодорхой мэдэх аргагүй болсон гэдэг юм. Тал нутгийн монголд Хэрээд, Найман, Өнгүүд, Тангуд, Бэгрин, Хиргис зэрэг овог аймгууд багтаж байв. Хэрээд буюу Хэрэйр хэмээх нэрийдлийн үгийн үндэс нь «хар» мөн бөгөөд тэдгээр нь Огус хааны эцгийн нэр Хар хаан буюу зүүн Европын Мажарын нутагт нүүдэллэсэн Хар Хүнтэй холбоотой гэж дээр өгүүлсэн билээ. Үүгээр үл барам хятадын дунд шингэгдээд одоо ул мөргүй болсон өмнөт Хүн-ий дотор ч хэрэйр овог олон байв. Миний үзэхээр Хэрээд бол Хүн хаант улсын үеэс монголын тал нутагт үлдэж хоцорсон эртний аймаг болно. XIII зууны үед Хэрээд аймаг нь Чингис хаанд нэгтгэгдэхээс өмнө, говийн арын төв нутгийг эзэлж байсан бөгөөд хожмын торгууд аймгийг Хэрээд аймгаас ирсэн гэдэг юм. Энэ нь Торгууд аймгийн хамгийн анхны Наран хаан гэдэг нь өөрөөр хэлбэл Хүн хаан гэдэгтэй яг нийцэж байна. Найман улс нь МЭ 907-1125 оны Хиданы байгуулсан Ляо улсын үеэс XIII зууны үед Чингис хаанд

нэгтгэгдэх хүртлээ Алтай уулын орчин тойронд нутаглаж байжээ. Одоогийн Хасаг үндэстний дотор найман овогтой хүмүүс олон байна. Хятад сурвалж бичгүүдэд Өнгүүдийг бас «цагаан татар» гэж нэрийддэг юм. Үүнээс үзэхэд өнгүүд нь дээр үед Татарын бүрэлдэхүүнд байсан байж магадгүй бөгөөд Хиданы Ляо улсын үеэс Онгон давааны орчимд нутаглаж байгаад хожим одоогийн Хөх хот орчимд Зүрчдийн Алтан улсын хэрэм хязгаарыг сахих албатай болоод Өнгүүд гэж нэрийдсэн бололтой. XV зууны үеийн Түшмэдийн Энгүүд отогийн нэрийдэл нь өнгүүдээс ирсэн байж мэднэ. Хятад сурвалж бичигт Тангууд аймгийн ноёрхогчдыг Хүн-ий хойчис гэдэг бөгөөд Тангууд аймаг МЭ 1032-1227 оны үед Яргай хотоор нийслэл болгож баруун Ся улсыг байгуулаад хамгийн сүүлд Чингис хаанд мөхөөгдсөн юм. Хиргис аймаг аль эрт МЭ XV зууны сүүлч үе хүртэлх нэг мянга долоон зуу орчим жилийн хугацаанд Енисей мөрний урсгал дагуу газраар нутаглаж Ойрадын Тогоон тайши-гийн хөвгүүн Абаборги тайдун вангийн ноёрхлын үед түүний гол хүч нь тэнгэр уулын ард цөмрөн орж хамгийн сүүлдээ дундад Азид нутагшжээ. Дээрх байдлаас авч үзвэл Рашидын хэлдэг тал нутгийн Монгол гэдэг нь үнэн хэрэг дээрээ монголын тал нутагт үлдэж хоцорсон Хүн, Түргүүдийн олон овог аймгийг хэлсэн ажээ.

XIII зуунаас өмнө тус бүрийн онцгой нэртэй байсан монгол овог аймгуудын дотор Гүрлигүүд аймгаас гадна Жалайр, Татар, Сөнид, Мэргид, Тулас, Томад, Булгачин, Хэрэмүчин, Орасуд /Урасуд/, Тамагалиг, Дархунд, Ойрад, Бархунд, Хори, Тэлэнгүд, Хасудии, Урианхан, Хорхан, Сахайд зэрэг их бага овог аймгууд багтана.

Хомохи аймгийг Түргүүдээр «Дадабъи» гэдгийг дээр өгүүлжээ. Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн «Ди-дэу-июй» болон түргүүдийн «Дадабъи» нь нэг нэрийн адил бус авиачилсан тэмдэглэл билээ. «Ди-дэу-июй» бол монголын Татау-татар хэмээх нэрийдлийн авиачилсан тэмдэглэл бас мөн бөгөөд тэр нь Табгача Вэй улсын үеэс одоогийн Шилийн гол аймгийн нутагт малжих болсон юм гэж дээр өгүүлсэн. Эдгээрээс авч үзвэл Хомохи-ийн Хи, Ши гэж тэмдэглэгдсэн хоёр салбар болон Татар аймаг бол Эртний Хүн хаант улсын үеийн Нугун аймгийн хойчис билээ. МЭ 653 онд Түргүүд хаант улсын хаан нь говийн ар, өвөр, Тэнгэр уулын дээд, доод нутаг, дундад азийн өргөн уудам нутгийн гурван хэсэг болгон хуваагаад баруун этгээдийн газар нутгийг хятадаар Ди-тэу хэмээн тэмдэглэсэн хаанд захируулсан гэдэг. Энэхүү Ди-тэу гэдэг нэр мөн л Татар гэдэг нэртэй холбоотой байж мэднэ. Гидан хаант улсын үед болоод түүний хаан, ноёдоос монголын өндөрлөгийн олон овог, аймгуудыг бүгд Жү бү буюу Жү бүгү гэж нэрийдэх болсон юм. Дээр дурдсан Жүбү болон Жүбүгү нь «Зовхи» буюу «Зовхис» гэдэг үг байжээ.⁴¹ «Зовхи» буюу «Зовхис» гэдэг үг нь татарын эрт цагийн нэрийдэл «Нугун»-тай адилаар булан, хязгаар гэсэн утгатай юм. Нуун мөрний зүүн эрэг

дээр байгаа одоогийн Чичигар хотын нэр ч монголын «хязгаар» гэдэг үгийн авиачилсан тэмдэглэл юм. Эдгээрээс үзвэл эрт урьдын цагийн Хүн хаант улсын Нугун аймагтай зах нийлж зэрэгцэн амьдарч байсан Гидан бол зүрчид, мөн Чин улсын эхний үеийн монголчууд нь өөрсдийнхөө эртний нэрийдлийн утга санааг түүхийн асар удаан хугацаанд мэдсээр иржээ. Жалайр гэдэг аймгийн нэрийдэл нь Хүн хаант улсын үеийн Жэ-лань овог Сяньби Шилбийн Лань овогос улиран хувьсаж ирсэн байж мэднэ. Язгуур монгол Хянган нуруунаас бууж хүчирхэгжин мандах явцад татар болон Жалайр аймаг их л саад харш болж байсан юм. Хүн хаант улсын үеэс XIII зууны үед язгуур монгол хүчирхэгжин мандах хүртэлх мянга илүү жилийн хугацаанд Татар аймаг Нуун мөрний урсгал дагуу газраас баруун тийш алхам алхмаар Шар мөрөн, Шилийн голын урсгал дагуу газарт нүүдэллэж тэндээс говийн ар, өврийн өргөн уудам нутгаар нутаглаж хамгийн сүүлд Хөлөн бойрын нутагт Чингис хаанд мөхөөгджээ. Түргүүд хаант улсын үед Татар аймгийн нэр сүр монголын өнөдрлөгөөс дундад Ази, Энэтхэг хүртэл алдаршжээ. Үүнээс үзвэл Татар аймгийн зарим хэсэг нь Ди-тэү хааныг дагаж баруун зүг нүүдэллэсэн бололтой. Киданы Ляо улс болон Зүрчидийн Алтан улсын үед монголын өндөрлөгийн Татар аймаг нь говийн арын олон овог аймгуудын ноёрхох гол тулгуур хүчин нь болж байжээ. Үүнээс болоод эртний хятад, Перс сурвалж бичгүүдэд Хүн, Сяньби Шилбийн дараа Шивы Шилбийн үед, мөн тэрчилэн монголын Юань улсын дараах монголын өндөрлөгийн овог, аймгуудыг нийдэм татар гэж нэрийддэг байжээ. Түргүүд үсгийн «Гүл тигины хөшөө»-д гардаг Одос татар -Гучин татар нь дээр өгүүлсэн чухам татар мөн бөгөөд тэдний овог аймгуудыг хэлсэн билээ. Мөн «Билэгэ хааны хөшөө»-нд хэлдэг Тогос-татар-Есөн Татар нь сая «Хуучин тан улсын түүх»-д тэмдгэлэсэн Шивы Шилбийн есөн аймаг бүгд найман аймгийг Хэлсэн ажээ. Түүний дотор яриангүй язгуур монгол багтах юм. Рашидын «Судрын чуулган»-д язгуур монголыг Ниругун Монгол, Тэрлигин монгол гэж хоёр хэсэг хуваадаг. Хиян нь Ниругун монголд багтдаг. Нэгүс нь Тэрлигэн монголд багтдаг. Гэвч дээр өгүүлсэнтэй адил Ниругун монголын дотор нь бас нэгүс хэмээх Чинус овог байдаг. Үүнээс үзвэл эрт дээр Огус хааны үеэс эхлэн. Бөртэ-чоноос онгон шүтээн болгодог байсан Хүн-Түргүүд-Монголын зарим аймгууд нь Хуа маралаар онгон шүтээн болгодог байсан аймгуудтай ураг садны харьцаатай байжээ. «Монголын нууц товчоо» эхлэнгүүт: «Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ Чоно ажгуу. Гэргий инү Хуа Марал» гэжээ.

XVII-XIX зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд: Чингис хааны язгуур дээдэс Бөртэ Чоныг Хуа Марал гэргийтэйгээ Жадын газарт зугатан очсон. Эсвэл Жадын газарт зугатаж очоод эргүй Хуа Марлыг гэргий болгож авсан гэдэг юм. Эртний хятад сурвалж бичгүүдэд Сяньби Шилбийг Сяньби аавтай, Хүн ээжтэй гэжээ.⁴²

Дээрхи тэмдэглэлүүд зарим талаар зөрөөтэй боловч Хиян болон Нэгүсийн хооронд ураг садны харьцаа холбоотой байсан гэдэг нь огт асуудалгүй юм. Тэгвэл язгуур монголын Хиян нь Бөртэ Чоноор онгон шүтээн болгодог байжээ. Хожим болоод Хиян болон Нэгүс хоорондоо харилцан шингэгдээд ураг садны харьцаа холбоо нь тодорхойгүй болжээ. Дээр өгүүлсэн Хиянаар голлосон Ниругун монголын дотор Нэгүс хэмээх Чонос овог байдаг нь үүнийг гэрчилж байна. XIII зуунаас одоо болтол эрдэмтэд нэрийдлийг тайлбарлах талаар адилгүй байна. Рашидын номонд монголыг Ниругун монгол Тэрлигин монгол гэж хоёр хуваадаг. Алун Гуа эхийн ариун нуруунаас үүссэн хойчисыг Ниругун монгол гэдэг гээд Тэрлигэн монгол хэмээх нэрийдлийн ухагдахууныг ер тодорхой тайлбарлаагүй билээ. Миний үзэхээр Ниругун монгол, Тэрлигин монгол гэдэг хоёр нэрийдэл бол харьцуулж нэрийдсэн нэрийдэл мөн. Тодорхой хэлбэл: Хянганы нурууны дээрхи монголыг Ниругун монгол Хянганы нуруун доорхийг Тэрлигин монгол гэдэг юм аа.

«Монголын нууц товчоон»-д МЭ 1206 онд Чингис хаан улс байгуулаад монголын өндөрлөгийн олон овог аймгуудыг мянган, түмэн болгож хуваахдаа Харахун Жидун, Тэрлигин, Алтай Тэрлигин гэж хуваасан юм. Монголчууд одоо болтол өвөг дээдсийн хүүр онгоноо аль зүгт ямар уулыг тэрлүүлэн оршуулсан гэж хэлсээр байгаа. Үүгээр үл барам эртний Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Гиданы төв их аймгийг хятадаар Те-ла гэсэн нь мөн л тэрэ гэдэг үгийн авиачилсан тэмдэглэл мөн. Бас хятадаар те-ла-и-ли жинь хэмээх цол зэргийг, Уулын доорхи цэрэг морьдыг захирах түшмэл гэж ойлгож болно.⁴³ Үүнд И-Ли-жинь гэдэг нь -лигин- буюу «иргэнэ гэсэн үгийн авиачилсан тэмдэглэл билээ. Тэгвэл Тэрлигин нь Ниругун монголтой харьцуулж нэрийдсэн нэрийдлээр үл барам бас ойн иргэн, талын иргэн, усны иргэн гэсэн нэрийдэлтэй харьцуулан нэрийдсэн нэрийдэл мөн. Тэрлигин гэдэг нэрийдэл нь язгуур монгол Хянганы нуруунаас буусны дараа сая буй болсон нэр биш, аль эрт Гиданы үед ч байсан юм. Үнэн хэрэгтээ Тэрлигин нь тусгай нэр биш, нийдэм нэр билээ.

Рашидын номонд Тэрлигин монгол дотроо: Нэгүс, Хонхирда, Урианхад, Ихирис, Олхонуд, Хонхадан, Хоролос, Элжигин, Хонлигуд, Орунар, Арулад, Хилиннуд, Ноягин, Үгүшин, Солдус, Илдургин, баягуд, Хингид зэрэг их бага овог аймгууд багтдаг. Эдгээр нь их төлөв түүхийн үнэн байдалтай нийцдэг. Ниругун монгол угийн /угаас хэлдэг/ Ниругун, Хинд Ниругун гэж хоёр хуваадаг гэж дээр өгүүлсэн билээ. Угийн /угаас хэлдэг/ Ниругун нь Хияд болон Нэгүс зугатаж очихоос өмнө Хянганы нуруунд амьдарч байсан эртний Оор хааны хойчисын захиргаан доорхи овог аймгууд, мөн Хүн болон зүүн Хуа-гийн хоорондох дайн байлдаанаас дүрвэн Хянганы нуруунд зайлж очсон Хиян болон Нигүсийн захиргаан доорхи овог аймгуудыг хэлсэн байх аа гэсэн билээ. Гэтэл « Монголын нууц товчоо»-ны

тэмдэглэлээс авч үзвэл угийн Ниругун болон Хияд Ниругуны доторхи олонхи нь хол хожим үед үүссэн овог аймгууд болох ажээ. Жишээлбэл: Рашидын хэлснээр Угийн Ниругуны дотор: Хадагин, Салжигуд, Тайчигуд, Хардахан, Шижугуд бас нэгүс гэдэг Чонос, Ноягин, Орогуд, Мангуд, Дөрвөн, Багарин, Барулас, Адаргин, Зүрчид, Будагад, Хадаргин, Тохурад, басуд, Сухан, Хингияд зэрэг овог аймгууд багтдаг гэнэ. Хияд Ниругуны дотор:Юргин, Жиншигуд. Хияд Ясар, Хияд Боржигин /бор нүдэт Хияд/ багтдаг гэнэ. Эдгээрийг гүнзгий судлах нь чухал юм. Язгуур монголын Хиянаар тэргүүлсэн овог аймгууд болон Нэгүсээр тэргүүлсэн овог аймгууд Эргүүнаа Хун-ы нутгаас нэгэн зэрэг нүүдэллэн гарсан биш ээ, харин өмнө хойно нүүдэллэсэн байх ёстой. Тийм биш бол язгуур монголоос Ниругун, Тэрлигин монгол гэж хоёр хуваахгүй юм. Үнэхээр Рашидын номонд Нэгүс зэрэг аймгуудыг Эргүүнаа Хун-ы газраас урьд / эрт/ нүүсэн гэжээ. I зууны үед умард Хүн-ий гол хүчин баруун тийш дундад Азид нүүдэллэхийг дагалдаж Зүүн Ху-гийн хойчис Сяньби Шилбийн Тавгача, Гидан, Аран зэрэг овог аймгууд урьд хожид Хянган нуруунаас монголын тал нутагт нүүдэллэн бууж ирсэн юм. Хэрэв тэд нарыг Зүүн Ху-гийн хойчисын олон овог аймгуудын анхны их нүүдэл гэж хэлбэл, Сяньби Шилбийн бүрэлдэхүүн Тэрлигин монголын нүүдлийг хоёр дахь удаагийн их нүүдлийн эхлэл гэж хэлж болно. Энэ нь мөн монголын тал нутагт үүнээс өмнө нутаглаж байсан овог аймгуудын доройтлын цаг үе байлаа. Олны Мэдээжээр МЭ 630 онд Монголын тал нутагт нутаглаж байсан Зүүн Түргүүд Хаант улс хятадын Тан улсад мөхөөгджээ. Үүний дараа монголын тал нутагт хятадаар Сюэ-янь-тө болон Хойт Түргүүд, Уйгур, Хиргис зэрэг хаант улс урьд хожид байгуулагдсан боловч язгуур монголын олон овог аймгуудын Их Хянган нуруунаас баруун тийш нүүдэллэн буухыг хориглож чадсангүй.

Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэснийг үндэслэвэл: Тан улс мөхсөний дараа Гидан хаант улс МЭ 907 онд байгуулагдав. Түүний захиргаан доор Хөлөн буйрын тал нутагт Юй-Чюэ Ди-Ле гэж Хятадаар тэмдэглэгдсэн хоёр аймаг нутаглаж байжээ. Юй Чюэ-г мөн Юй-гү-ли буюу Юй-Чюэ-и Ди-Ле--г бас Ди-Ле-дэ гэж бичдэг. Үүнд Юй-Чюэ-г «Нэгүс», Юй-гү-ли буюу Юй-Чюэ-г «Нэгүс», Ди-ле-г «Тэрлигин», Ди-ле-дэ гэдгийг «Тэрлигид», У гу гэдгийг «Огус» гэж тус тус сэргээхэд огт асуудалгүй юм. Тэгвэл Тэрлигин монгол Эргүүнаа Хун-ы газраас Хөлөн буйрын тал нутагт бууж ирээд эрт урьдын цагийн Нэгүс буюу Огус хэмээх нэрийдлээ хэрэглэж байсны хамт бас өөрсдийгөө Эргүүнаа Хун-ы газраас бууж ирээгүй байсан Ниругун монголоос ялгаж Тэрлигин Монгол гэж нэрийддэг байжээ. Нэгүс-ийг бас Огус гэдэг нь Хүн- Түргүүд-Монголын язгуур гарал нэг болохыг дахин нэг удаа нотлож байна. Гидан хаант улс говийн арын нутгийг нэгтгэсний дараа Хөлөн буйр болон Хэрлэн голын доод урсгал дагуу нутагт Огус тэрлигинийг захирах цэргийн яам

байгуулжээ. Тухайн үед хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Тэрлигиний найман аймаг гэдэг нь МЭ 735 онд Түргүүд үсэг дээр босгосон «Билэг хааны хөшөө»-нд тэмдэглэсэн Татар-Есөн Татарыг хэлсэн байжээ.

Түргүүд үсгийн хөшөөний бичиг болон хятадын «Хуучин Тан улсын түүх»-д есөн татар буюу Шивэйн есөн аймаг гэж тэд нарын бүх овог аймгуудыг хэлсэн байжээ. Үүний зэрэгцээгээр Зүүн Ху-гийн хойчис буюу түүний захиргаанд байсан олон овог аймгууд өөрсдөө найман ор болгон зохион байгуулж нэрийддэг заншилтай байжээ. Жишээлбэл: Табагача-гийн найман аймаг буюу Сяньби Шилбийн найман улс, Гиданы найман аймаг, Гуулийн найман аймаг, Огус Тэрлигиний найман аймаг, найман муж Монгол, найман отог цахар гэх мэт. Манай хүрээлэнгийн нэг ажилтны хадгалж байгаа «Хөх түүх» хэмээх гар хуулбар дэвтэрт Чингис хааны 1206 онд дөчин найман түмэн Бэтэ улсын эзэн болсон гэж буй. Энд найман түмэн нь мөн л Зүүн Ху-гийн хэллэг болно. Эдгээрийг яасан ч гэнэтийн тохиолдол гэж хэлж болохгүй. Монгол, Ойрад хоёрын үед Ойрад нь XIII зууны үеийн дөрвөн мянган ойрадыг дурсгаж өөрсдөө заавал дөрвөн ор болгож зохион байгуулдаг байсан юм. Бодоход, эрт урьдын цагт Хянган нуруунд зугатан орсон Зүүн Ху-гийн олон овог аймгууд Хүн-ий Мэ-дү хааны дайралтыг эсэргүүцэх явцад өөрсдөө найман хэсэг болж зохион байгуулсан байх аа. Энэхүү түүхэн явдлыг дурсгаж Зүүн Ху-гийн хойчис буюу түүний захиргаанд байсан овог аймгууд өөрсдөө заавал найман ор болон зохион байгуулдаг заншилтай болжээ. Гэвч Тэрлигин монгол буюу огус тэрлигин найман аймгийг 10 дугаар зууны үед сая Хянган нуруунаас бууж ирсэн гэвэл олонхи түүхэн үйл явдлуудтай нийцэхгүй юм.

Мэ VII зууны эхний үед Хөлөн нуурын баруун өмнүүр Уйгууртай зах нийлдэг Шивэй Шилбийн хятадаар ө-сү-гү гэж тэмдэглэсэн аймаг байсан гэж дээр өгүүлсэн билээ. Хэрэв энэ аймгийн нэрийн хоёр, гурав дахь үсгийг байр нь солигдсон үзвэл тэр нь Ө-гү-сү болоод яг Огус гэдэг үгийн авиачилан тэмдэглэсэн болно. Ингэснээр монгол хятад үгийн авиа харилцан зохицохоос гадна хожмын Огус тэрлигин газар нутагтай яв цав нийцэх болно. Ийм болохоор Тэрлигин монголыг ядахдаа МЭ VII зуунаас өмнө Эргүүнаа Хун-ы газраас Хөлөн буйрын тал нутагт нүүдэллэж ирсэн гэж үзэж болно. Тэгвэл -Хуучин тан улсын түүх»-д тэмдэглэсэн монгол шилбэ нь зөвхөн Ниругун Монголыг хэлсэн байжээ. Түүнд Тэрлигин монгол багтахгүй юм. Ниругун монгол нь Тэрлигин монголоос дараа чухам хэзээ Хянган нуруунаас буусан тухай бодитой тэмдэглэл үгүй юм.

«Монголын нууц товчоон»-д Чингис хааны язгуур дээдэс Бөртэ Чоно тэнгис гаталж Бурхан Халдун газарт нүүн ирсний дараах хорин хоёр үеийн дээдсийг тэмдэглэжээ. Үүнээс Бөртэ Чоно Чингисийг эс тооцвол хорин үе бөгөөд нэг үеийг хорин таван насаар бодвол Батчихан Бурхан Халдуны газарт ирснээс Чингис хаан хүртэл

яг таван зуун жил болой. Тэгвэл Ниругун монгол Эргүүнаа Хун-ы газраас гарч ирсэн нь YII зууны дундаг үе өөрөөр хэлбэл Тэрлигин Монголын дараа зуун жил болоогүйгээр Эргүүнаа Хун-ы нутгаас гарсан ажээ.

Хятад сурвалж бичгийн тэмдэглэлийг үзэхэд МЭ 907-960 оны үед хятадаар Ме-же-зы хэмээх аймаг Онон мөрний урсгал дагуу газарт нутаглаж байжээ. Тэр нь мөн л монгол гэдэг нэрийдлийн авиачилсан тэмдэглэл Ниругун монголыг хэлжээ.

Тэрлигин монгол, Ниругун монгол эргүүнаа Хун-ы газраас гарахдаа явж өнгөрсөн зам, тэд нар хоорондоо дахин нэгдсэн явц зэрэг нь мөн тодорхойгүй. Бодоход МЭ 630 онд Зүүн Түргүүд хаант улс мөхөөгдөхийн хойно өмнө Нэгүс тэргүүтэй Тэрлигин монголын овог аймгууд Эргүүнаа Хун нутгаас баруун өмнө Хөлөн буйр, Буйр нуур орчимд очиж нутаглаад тэндээсээ Хэрлэн голыг өгсөж Туул голын урсгал дагуу Бурхан Халдун уулын орчимд сүр хүчээ өргөтгөжээ.

Хиян тэргүүтэй Ниругун монгол нь YII зууны дунд үеэс хойно Эргүүна Хун-ы газраас баруун тийш Онон мөрнийг өгсөн Бархужин Төхөмийн нутгийг өнгөрсөн Бурхан Халдун уулын орчимд хүрчээ.

МЭ 715 онд Хойд Түргүүд хаант улсын Билэг хаан Түргүүд Огус аймгийг дайлж ихээр ялсан үед Тогос Татар-Тэрлигин монгол Туул голын урсгал дагуу Аху хэмээх газарт түргүүд Огус аймгийг дэмжиж Билэг хаантай дайлалдсан гэдэг юм.⁴⁴ Ийнхүү Туул голын урсгал дагуу газарт нь Тэрлигин монголд эзлэгдээд Ниругун монгол болон Тэрлигин монгол дахин нэгдсэн бололтой. Мэ 744 онд Уйгур хаант улс байгуулагдаад говийн арын газар нутгийг эзлэхээр Сэлэнгэ мөрний урсгал дагуу нутагт Тогос татар-есөн татар болон Найман Огустай олон удаа дайн хийжээ. Үүнээс үзвэл энэ үед Тэрлигин монгол нь нэгэнт хоёр хэсэг болоод Тогос татар-Есөн татар, Найман Огус гэж нэрийддэг болсон байжээ МЭ 840 онд уйгур хаант улс нь Хиргист мөхөөгдөв. Гэтэл Хиргис нь говийн арын тал нутагт их удалгүй Енисей мөрний урсгал дагуу уг нутагтаа буужээ. Энэ нь тэр үед Тэрлигин монгол болон Ниругун монголын сүр хүчин ихэдсэнээс болсон байх аа. Мэ X-XII зууны үед монголын өндөрлөгийн олон овог аймаг удаа дараа Гиданы Ляо улс болон зүрчидийн Алтан улсын ноёрхолд байжээ. Энэ үед Ниругун монгол нь Жалайр, Татар аймгийн дарлалыг амсдаг байжээ. Монголын нууц товчоон»-д Чингис хааны 3 дугаар үеийн дээдэс Хабул хааныг хамаг монголын хаан болсон гэдэг билээ. Хабул хааны үеийн хамаг монгол дотор Ниругун монгол, Тэрлигин монголын бүх овог аймгууд багтсан байх ёстой. Учир нь МЭ 1115 онд Зүрчидийн Алтан улс байгуулагдсан нь дараа Хятадын сурвалж бичгүүдэд өнгөрсний Тэрлигин, Найман Огус, Есөн Татар зэрэг нэрийдэл харагдахгүй болоод тэд нарыг нийдэм Монгол хэмээх нэрээр орлуулдаг болжээ.

«Монголын нууц товчоон»-д Нэгүс хэмээх нэрийдлийн тухай эл зүйлийн тэмдэглэл болон Чингисийн авга Нэхүн /Нэгүн тайж зэргээс авч үзэхэд Хабул хааны үеэс эхлэн Тэрлигин монголын Нэгүс зэрэг овог аймгууд Ниругун Монголын Хишдын харъяанд оржээ. Монголчууд бид хамаг монгол хэмээх нэрийдлийг монголын хамгийн анхны хаан Хабул хааны үеэс Чингис хааныг нас бартлаа хэрэглэж байжээ. Чингис хааны үеийн хамаг монгол дотор язгуур монголоос гадна тал нутгийн монгол болон угаас тусдаа онцгой нэртэй байсан монголын олон овог аймгууд багтдаг байжээ.

Энэхүү хэсэгт өгүүлсэн яршиг төвөгтэй зүйлүүдийг дүгнэж хэлбэл:

Хүн-Түргүүд-Монгол бол язгуур дээдэс нэгтэй. Тэд нарын нийтийн язгуур дээдэс бол Абулжа хаан, Төв Яхуй билээ. Абулжа хааны дөрөвдүгээр үеийн хойчис Огус хаан. Хүн бол Огус хааны шууд залгаа хойчисын захиргааны овог аймаг мөн. Түргүүд бол Огус хааны төрсөн ах дүү нар болон үеэлэд ах дүү нарынхан захиргааны овог аймаг билээ. Монгол бол Огус хааны гурван авга нарын захиргааны овог аймгууд билээ. Хүн-Түргүүд-Монголын олон овог аймгууд нь язгуур дээдэс нэгтэй болохоор урт удаан түүхийн явцад тэд нарын аль нь хүчирхэгжин мандвал бүгдээрээ түүнийхээ нэрийг хэрэглэх заншилтай байжээ. Үүгээр үл барам Хүн-Түргүүд-Монголын олон овог аймгууд үргэлж харилцан хутгалдаж уусч байсан юм. Монголоор жишээлэхэд: Түүний ноён аймаг Хияны захиргаанд Хүн Түргүүд-Монголын олон овог аймгуудын алин ч байдаг байжээ. Одоогоос 2-3 мянган жилийн өмнөөс эртний хятад хүмүүс Хүн Түргүүд-Монголчуудын нутагладаг зүг чиглэлээр нь Хүн, Зүүн Ху гэж ялгаж тэмдэглэдэг байжээ. Гэвч Хүн, Зүүн Ху-г адил бу, хоёр өөр угсаа үндэстэн гэж хэлж болохгүй юм. Тэд хожим болоод сая холдож салсан билээ. Энэ бол тус өгүүллийн судалсан хүрээ хэмжээний гаднах асуудал юм. Хятад сурвалж бичгүүдэд Хүн Түргүүд-Монголын олон овог аймгуудыг нийтэд нь Ху буюу Бэй-ди гэж нэрийддэг. Тэгвэл Дөчин түмэн Бэ-тэ /Бэй-ди/ улсын дөчин түмэн нь хаанаас яаж ирснийг үргэлжлэлээс уншаарай.

3.Хасбагана монгол бичгээс буулгав.

Зүүлт

- 1.Эрдэнийн товч.115-116, 143-144т
2. Их шар тууж.80т, Алтан хүрдэн мянган хигээст 17т
- 3.»Гангын урсгал» 41т
- 4.»Хөх судар» тэргүүн дэвтэр.1957.ӨМАХХ.34 т
- 5.»Гангын урсгал» 41т
- 6.Монголын нууц товчоо» тэргүүн дэвтэр 99-101т
- 7.»Хуучин Тан улсын бичиг» 199-р боть.149т.Хятадын Ардын Хэвлэлийн Хороо.1975

- 8.Сыма Цян.»Түүхийн тэмдэглэл» 123-р боть 3161т. Хятадын Ардын Хэвлэлийн Хороо. 1959
- 9.»Юань төрийн түүх» 1-33т
10. Сыма Цян.»Түүхийн тэмдэглэл» 1975
- 11.»Түргүүд түүхийн цуглаан» 16 боть 857-908т Шанхайн Ардын Хэвлэлийн Хороо. 1957
- 12.Судрын чуулган» I боть 250т
- 13.Широ Хаттори «Монгол хэлнүүдийн салсан оныг судлах нь» 172-173т.»Хэл зохиол».1967
- 14.»Огус хааны дуулт» 18т
- 15.Ван Ли «Хятад хэлний авианы түүх» 1986
- 16.Монгол түүхийн тухай өгүүлүүд» 40т
- 17.Лин Хан «Хүн Хүннүгийн түүхийн материалан цуглаан» 2т Хятадын АХХ.Дээд дэвтэр. 1988
- 18.»Шинэ таван төрийн түүх» 73-р боть Хятадын Намын Товчоо. 1974
- 19.»Хөх судар» тэргүүн дэвтэр 35т
- 20.» Хүннүгийн түүхийн материалын цуглаан» дээд дэвтэр 23т
- 21.Огус хааны дууль» 26т
- 22.»Судрын чуулган» 1-р боть 250т
23. »Огус хааны дууль» 19-26т
- 24.»Судрын чуулган» 1-р боть 125,135т
25. Мөн тэнд 121-124т
26. »Хүннүгийн түүхийн материалын цуглаан» Дээд дэвтэр 123-124т
- 27.мөн тэнд 9т
- 28.»Огус хааны дууль» 22т
- 29.»Судрын чуулган» 1-р боть 239т
- 30.»Түүхэн тэмдэглэл» Хятадын АХХ 1-р дэвтэр 6т, 1959.
31. Ш.Бира «Төвдөөр бчисэн монголчуудын түүхийн зохиол» 20-21т, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн Хороо.1992
- 32.Алтан-Оргил.»Хөх хотын түүхийн монгол сурвалж бичиг» 132т, Өвөр Монголын Хэвлэлийн хороо. 1989
- 33.»Судрын чуулган» 1-р боть 252т
34. »Судрын чуулган» 1-р боть 251т
- 35.Мөн тэнд 1-р боть 129т
- 36.Мөн тэнд 1-р боть 6т
- 37.»Хойд Хан улсын бичиг» 90-р боть 10-р дэвтэр 2979т Хятадын Намын Товчоо.1965
38. »Судрын чуулган» 1-р боть 142т
- 39.»Хуучин Тан улсын бичиг» 199-р боть 149т Хятадын Намын Товчоо 1975.
40. Судрын чуулган» 1-р боть 126т

41. Монголчууд одоо болтол дөрвөн зүг найман зовхис гэж хэлдэг юм. Зовхи бол булан, өнцөг гэсэн утгатай болно.
42. Ма Чэншо «Ухуань хийгээд Сяньби» 3-5т Шанхай: АХХ 1962
43. «Ляо улсын түүх» 116-р боть 1974. Хятадын Намын Товчоо 1534т
44. Түрэг үсгийн «Билгээ хааны хөшөө» Ар талын 28-33-р мөр
45. 1225 оны үед бичигдсэн «Есүнгэйн чулуун бичиг»-т буй. мөн «Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд» 5т Үндэсний Хэвлэлийн Хороо 1983.

ЖУЖАНЫ ХААНТ УЛС, ТҮРЭГИЙН ЭЗЭНТ ГҮРЭН
/IY-YII зуун/

Академич Н.Ишжамц

IY-YII зууны үед Ар Монгол буюу өнөөгийн Монгол улсын дэвсгэр нутаг дээр оршин тогтнож байсан Төв Азийн нүүдэлчин Жужан, Түрэг улсуудын түүх, амьдрал хөгжлийн талаархи гол сурвалж бичиг баримтууд дундад зууны Хятадын угсааны төрүүдийн түүхийн сударт нэлээд байдаг. Мөн түрэг, перс, араб, унгар хэлний ном зохиолд зарим баримт, мэдээ байдаг. Сүүлийн зуу гаруй жилд Монгол, Хятад, Казахстан, Тува, Кыргыз, Унгар зэрэг улс орнуудын нутаг дэвсгэр дээр хийсэн археологийн шинжилгээгээр Түрэгийн холбогдолтой маш чухал баримт олдсоор байна. Хятад, Унгар, Монголоос авах Жужаны холбогдолтой археологийн баримт бас нээгдэж олдов. Тэр бүхэн Жужан, Түрэгийн талаархи бидний мэдлэгийн гол суурь болж байна.

Харин Жужан¹, ялангуяа түрэгийн² холбогдолтой судалгааны зохиол тэдгээрийн дотор орсон баримт материал, судалгаа шинжилгээ, дэвшүүлсэн санаа дүгнэлтүүд маш сонин бөгөөд чухал.

Жужан, Түрэгийн түүхийн баримт, тэдгээрийн холбогдолтой судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан Жужаны хаант улс, Түрэгийн эзэнт гүрний түүхийн тоймийг зураглан гаргаж болох боломжтой байна.

1. Жужаны хаант улс

Дорно Өрнийн суурьшмал иргэншилт улс гүрнүүдийн хооронд Ази-Европын нүүдлийн соёлт улс түмнүүд эрт үеэс оршин амьдарсаар ирсэн юм. Евро-Азийн зүүн хэсэгт манү-түнгүс угсааны улс аймгууд, баруун хэсэгт нь Түрэг угсааны улс аймгууд оршин амьдарч байсан бол тэдний хооронд төв хэсэгт нь гол төлөв монгол угсааны улс аймгууд оршин амьдарч байв.